



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 12 дугаар сарын 11
№46 (1294)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

595.	Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай	Дугаар 82	3565
596.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 83	3567
597.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 84	3569
598.	Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 94	3571
599.	Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 95	3573
600.	Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай	Дугаар 101	3575
601.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 102	3577
602.	Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай	Дугаар 103	3578
603.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох тухай	Дугаар 104	3579
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
604.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 103	3580



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

605.	Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт батлах тухай	Дугаар 195	3581
606.	Журам батлах тухай	Дугаар 199	3714
607.	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай	Дугаар 200	3723
608.	Жагсаалт шинэчлэн батлах тухай	Дугаар 202	3741

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 60 албан хаагчтай байхаар тогтоосугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны холбогдох төсөв, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах зардлын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Төгсөмтөгний нэр
Төгсөмтөгний нэр
Төгсөмтөгний нэр

Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..
Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр – Төгсөмтөгний нэр ..

Төгсөмтөгний нэр

Төгсөмтөгний нэр

Модуль Фолд_02 Yekhi Horik and Dordagaa



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын “Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын алба, Төв” хэсгийг “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газар, Төв” гэж, “Тэргүүн түшмэл” ангиллын “АА-1” зэрэглэлийн “Ажлын албаны дарга” гэснийг “Мэдээллийн технологийн төвийн захирал” гэж, “АА-2” зэрэглэлийн “Мэдээллийн технологийн төвийн захирал” гэснийг “Газар, Төвийн дарга” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа “ТӨ-IV”-ийн тусгай албан тушаалд “Авлигатай тэмцэх газрын дарга” гэсний дараа “, Сонгуулийн ерөнхий хорооны дарга” гэж, “ТӨ-VI”-ийн Захиргааны албан тушаалд “Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга” гэсний дараа “, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга” гэж тус тус нэмсүгэй.

2.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа “ТӨ-V”-ийн тусгай албан тушаалын “Сонгуулийн ерөнхий хорооны дарга” гэснийг “Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга” гэж өөрчилсүгэй.

3.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа “ТӨ-VI”-ийн тусгай албан тушаалын “, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга” гэснийг хассугай.

4.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39¹.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журам”-ын дагуу ирүүлсэн PN-202310-70621 дугаартай нийтийн өргөдөл, PN-202310-96904 дугаартай нийтийн өргөдлийн үр дүнг үндэслэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын нэмэгдсэн өртгийн албан татвар болон татварын орчинд үнэлэлт, дүн шинжилгээ хийж, шударга ёсны зарчимд нийцүүлэн татварын орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/-нд даалгасугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан асуудлаар шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Монгол Улсын Сангийн сайд /Б.Жавхлан/ нарт тус тус даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Л.МӨНХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар
хот

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 80 дугаар тогтоолыг үндэслэн Хишгээгийн Нямбаатарыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчит зарим компаниудын асуудлаарх Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчит зарим компаниудын асуудлаарх Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг нэмсүгэй.

3.Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболдыг сонгосугай.

2.Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгаланг, Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужинг, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцагийг тус тус улируулан сонгосугай.

3.Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшинг Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

4.Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Хүндэтгэсэн
Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 /

Төрийн мэдээлэл / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 /

Төрийн мэдээлэл / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 /

Төрийн мэдээлэл / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 /

Төрийн мэдээлэл / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 /

Төрийн мэдээлэл / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 /

Төрийн мэдээлэл / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 / 1. Ө.М.А. / 2023 он / 46 / 1294 /

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Модуль Фолд_02 Yeld Horak 02 Doalgala



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар
хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жаргалсайханы Хунанг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian Folio_02 Ukh Hural of Davaajargal

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠶ᠋ᠢᠨ
ᠬᠤᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠡᠷᠬᠡᠢ ᠶ᠋ᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠶ᠋ᠢᠨ

ᠲᠤᠭᠲᠤᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠡᠷᠬᠡᠢ
ᠶ᠋ᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ

ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ

ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ

ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠨᠠᠭ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэгийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргалыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 195

Улаанбаатар
хот

Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5⁵ дугаар зүйлийн 5⁵.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг 1 дүгээр хавсралт, Барилга, хот байгуулалтын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 2 дугаар хавсралт, Боловсрол, шинжлэх ухааны салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 3 дугаар хавсралт, Зам, тээврийн хөгжлийн салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 4 дүгээр хавсралт, Соёлын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 5 дугаар хавсралт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 6 дугаар хавсралт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 7 дугаар хавсралт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 8 дугаар хавсралт, Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 9 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 10 дугаар хавсралт, Эрчим хүчний салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 11 дүгээр хавсралт, Стандарт, хэмжил зүйн салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг 12 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Салбарын хэмжээнд дээрх шалгуур, үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, шалгалтад хамруулах давтамжийн хугацааг хяналтын чиглэлээр жил бүр баталж, мөрдүүлэхийг салбарын хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3.Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Шалгуур,



үзүүлэлт батлах тухай” Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 195 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

01.БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОБЪЕКТЫГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

01.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх байдлаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Тухайн орчинд үзүүлэх бохирдлын цар хүрээ		
1.1	Агаар, хөрс, усыг зэрэг бохирдуулах аюултай	10
1.2	Аль нэгийг нь илүү бохирдуулах аюултай	5
1.3	Алийг нь ч бохирдуулахгүй	1
Хоёр. Үйлдвэрлэлд ашиглаж буй химийн бодис		
2.1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа тэсэрч дэлбэрэх болон А зэрэглэлийн химийн хортой болон аюултай бодис ашигладаг (цианит, натри, хром, мөнгөн ус, хүчил, шүлт гэх мэт)	10
2.2	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа А зэрэглэлийн химийн хортой болон аюултай бодисоос бусад химийн бодис ашигладаг	8
2.3	Хор аюул багатай химийн бодис ашигладаг (үйлдвэрлэлийн зориулалттай угаалгын бодис, будагч бодис гэх мэт)	3
2.4	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа химийн бодис ашигладаггүй	1
Гурав. Байгалийн нөөц баялаг ашиглалт		
3.1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа байгалийн нөөц баялгийг шууд ашигладаг (ус, рашаан, ой, ургамал, ан, амьтан, ашигт малтмал гэх мэт)	10
3.2	Бэлтгэгдсэн байгалийн нөөц баялгийг боловсруулдаг	5
3.3	Байгалийн нөөц баялгийг ахуйн зориулалтаар ашигладаг	1
Дөрөв. Үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын зэрэглэл		
4.1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад аюултай хог хаягдал гаргадаг	10
4.2	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хяналттай хог хаягдал гаргадаг	8
4.3	Ахуйн болон үйлдвэрлэлийн энгийн хог хаягдал гаргадаг	3
Тав. Үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлын хэмжээ		
5.1	Хоногт гаргаж байгаа хог хаягдал нь 5 м ³ -ээс дээш	10
5.2	Хоногт гаргаж байгаа хог хаягдал нь 2-4 м ³	5
5.3	Хоногт гаргаж байгаа хог хаягдал нь 1 м ³ хүртэл	1
Зургаа. Агаарын бохирдол үүсгэх эх үүсвэр		



6.1	Агаарыг их хэмжээгээр бохирдуулах эрсдэлтэй үйл ажиллагаа (уур үйлдвэрлэл, дулаан үйлдвэрлэл, зам, барилгын материалын үйлдвэрлэл, цэвэрлэх байгууламж гэх мэт) явуулдаг	10
6.2	Агаарыг дунд хэмжээгээр бохирдуулах эрсдэлтэй үйл ажиллагаа (хөнгөн үйлдвэрлэл) явуулдаг	5
6.3	Агаарыг бага бохирдуулах үйл ажиллагаа явуулдаг	1
Долоо. Хөрсний бохирдлын стандартын түвшин		
7.1	Хөрсийг их хэмжээгээр бохирдуулах, эсхүл элэгдэл, эвдрэлд оруулах эрсдэлтэй үйл ажиллагаа (арьс, ширний үйлдвэрлэл, авто засварын газрууд, ил уурхай, цэвэрлэх байгууламж гэх мэт) явуулдаг	10
7.2	Хөрсийг дунд хэмжээгээр бохирдуулах эрсдэлтэй үйл ажиллагаа (авто зам, далд уурхайн үйлдвэрлэл) явуулдаг	5
7.3	Хөрсийг бага бохирдуулах үйл ажиллагаа явуулдаг	1
Найм. Байгальд хаягдах бохир усны стандартын түвшин		
8.1	Ашигласан усыг цэвэршүүлэхгүйгээр хүрээлэн буй орчинд шууд хаядаг	10
8.2	Ашигласан усаа ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлдэг	5
8.3	Ашигласан усаа "Дахин ашиглах цэвэрлэсэн усны стандарт"-ын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлж дахин ашигладаг	1
Ес. Үйлдвэрлэл, үйлчилгээний байршил		
9.1	Хүн амын суурьшлын бүсэд болон тухайн үйл ажиллагааг хориглосон бүсэд байрладаг, эсхүл тусгай хамгаалалттай газар нутаг болон ой, усан сан бүхий газарт үйл ажиллагаа явуулдаг	10
9.2	Зөвшөөрөгдсөн үйлдвэрийн бүсэд байрладаг, эсхүл тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс, ой, усан сан бүхий газраас зөвшөөрөгдсөн бүсэд үйл ажиллагаа явуулдаг	1
Арав. Мэргэшсэн боловсон хүчнээр хангагдсан байдал		
10.1	Байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй, эсхүл тухайн чиглэлээр мэргэжилтэй, дадлагажсан ажилтан ажилладаггүй	10
10.2	Мэргэжлийн байгууллагатай гэрээтэй	5
10.3	Байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй, эсхүл тухайн чиглэлээр мэргэжилтэй, дадлагажсан ажилтан ажилладаг	1
Арван нэг. Нөхөн сэргээлт, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах түвшин		
11.1	Байгалийн нөөц баялаг ашиглаад нөхөн сэргээлт хийдэггүй, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авдаггүй	10
11.2	Тухайн байгалийн нөөц ашигласан талбайн 75 хувьд нь биологийн нөхөн сэргээлт хийсэн, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ төлөвлөж, зам талбайг цардсан, ногоон байгууламжтай	5
11.3	Байгалийн нөөц баялаг ашиглаад биологийн нөхөн сэргээлт хийдэг, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авдаг, зам талбайг цардсан, ногоон байгууламж, цэвэрлэх байгууламжтай	1
Арван хоёр. Байгаль орчныг хамгаалах дотоод хяналт		



12.1	Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй	10
12.2	Дотоод хяналтын нэгж (ажилтан)-тэй боловч үйл ажиллагаа хэвшээгүй	5
12.3	Дотоод хяналт тогтмолжсон	1
Арван гурав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
13.1	Өмнө хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
13.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
13.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

65-130 оноо авсан бол их эрсдэлтэй

40-61 оноо авсан бол дунд эрсдэлтэй

39 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

01.2. Байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Байгалийн нөөц баялаг ашиглагчийн төрөл		
1.1	Байгалийн нөөц баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг	10
1.2	Анхан шатны боловсруулалт хийж зах зээлд гаргадаг	5
1.3	Байгалийн нөөц баялгийг ахуйн зориулалтаар ашигладаг	1
Хоёр. Үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн нөөц баялаг ашиглагчийн цар хүрээ		
2.1	Байгалийн нөөцийг жилийн турш болон ашиглах хэмжээний дээд хэмжээнд хүргэж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигладаг	10
2.2	Байгалийн нөөцийг улирлын чанартай болон тухайн жилд ашиглах хэмжээнийхээ 60-аас доошгүй хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигладаг	8
2.3	Байгалийн нөөцийг хэмнэлттэйгээр, тухайн жилд ашиглах хэмжээнээс 60 хувиас бага үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигладаг	1
Гурав. Нөхөн сэргээлт, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах түвшин		
3.1	Тухайн үйлдвэрлэлд ашиглаж байгаа байгалийн нөөц баялаг нь нөхөн сэргээх боломжгүй	10
3.2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагын хэмжээнд нөхөн сэргээлт хийдэггүй	8
3.3	Байгалийн нөөц баялаг ашиглагч нь нөхөн сэргээлтийг тогтмол хийдэг, нөхөн сэргээх материал, тоног төхөөрөмж, бааз суурьтай (Мод үржүүлгийн газар, тарьц, суулгац, үрийн нөөцтэй, тарималжуулдаг)	1



Дөрөв. Байгалийн нөөц баялгийн ашиглалтаас үүссэн хаягдал		
4.1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүссэн хаягдлыг дахин боловсруулж бүрэн ашигладаггүй	10
4.2	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарсан хаягдлын 50-аас доошгүй хувийг ашигладаг	5
4.3	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүссэн хаягдлыг дахин боловсруулж бүрэн ашигладаг	1
Тав. Хүний нөөцийн хангалт		
5.1	Мэргэжлийн байгууллагад тавигдсан шаардлагад заасан байвал зохих мэргэжлийн боловсон хүчин 70 хувиас доош хангагдсан.	10
5.2	Мэргэжлийн байгууллагад тавигдсан шаардлагад заасан байвал зохих мэргэжлийн боловсон хүчин 71-90 хувь хангагдсан	5
5.3	Мэргэжлийн байгууллагад тавигдсан шаардлагад заасан байвал зохих мэргэжлийн боловсон хүчин 91-100 хувь хангагдсан	1
Зургаа. Техник, тоног төхөөрөмж, машин механизм		
6.1	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь стандарт хангасан тоног төхөөрөмж, техник, машин механизм хэрэгсэлгүй	10
6.2	Байгалийн нөөцийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж нь хаягдалгүй ашиглах нөхцөл хангагдаагүй	8
6.3	Байгалийн нөөц баялаг ашиглахдаа стандартын шаардлага хангасан, байгалийн нөөцийг хаягдалгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн, байгальд ээлтэй, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, эсхүл уламжлалт арга технологи, ердийн хөсөг ашигладаг	1
Долоо. Өмнөх хяналт шалгалтын түүх		
7.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомжийг ноцтой зөрчсөний улмаас их хэмжээний торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтын дүнд илэрсэн зөрчил давтан гардаг, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож байсан хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
7.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
7.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
Найм. Дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлсэн байдал		
8.1	Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй	10
8.2	Дотоод хяналтын нэгж (ажилтан)-тэй боловч үйл ажиллагаа хэвшээгүй	5
8.3	Дотоод хяналт тогтмолжсон	1
<p>Үнэлгээ:</p> <p>40-80 оноо авсан бол их эрсдэлтэй</p> <p>24-39 оноо авсан бол дунд эрсдэлтэй</p> <p>23 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй</p>		
----o0o----		

Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 195 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**02.БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ОБЪЕКТЫГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД
ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

№	Чиглэл	Эрсдэлийн шалгуур, үзүүлэлтийн нэр, код
1		02.1 Барилга, байгууламжийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
2	№02 1.Барилга, хот байгуулалт (төлөвлөлт, барилгын материал), инженерийн байгууламж, шугам сүлжээ (цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, халаалт, агаар сэлгэлтийн барилга байгууламж, шугам сүлжээ), өргөх механизм, газар, геодези, зураг зүйн хяналт	02.2 Барилгын материал үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
3		02.3 Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
4		02.4 Инженерийн байгууламж, шугам сүлжээг (цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, халаалт, агаар сэлгэлтийн барилга байгууламж, шугам сүлжээ) эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
5		02.5 Өргөх байгууламж үйлдвэрлэдэг, ашигладаг этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
6		02.6 Газрын нөөц ашиглалт, өмчлөгч, эзэмшигч, ашиглагч этгээдийг газар, түүний хөрсөнд сөрөг нөлөөлөл үзүүлэх байдлаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
7		02.7 Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
8		02.8 Хот байгуулалт, уул уурхайн ашиглалт, ашигт малтмалын нөөц тооцоолол, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтцийн геодезийн хэмжилтийн үйл ажиллагааг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт



02.1. Барилга, байгууламжийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг . Барилгын зориулалт		
1.1	Төрийн тусгай хамгаалалтын, цэвэр усны эх үүсвэр, улс орны стратегийн онцгой ач холбогдол бүхий үйл ажиллагаа явуулдаг барилгууд, газар хөдлөлтийн дараах хор уршгийг арилгах үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай барилга, байгууламжууд	10
1.2	Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууц, үзвэр, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний барилгууд, цэвэрлэх байгууламж	8
1.3	Бусад (агуулах, түр барилга гэх мэт)	1
Хоёр. Газар хөдлөлийн мужлал		
2.1	Газар хөдлөлийн 9 баллын бүсэд байрладаг	10
2.2	Газар хөдлөлийн 8 баллын бүсэд байрладаг	5
2.3	Газар хөдлөлийн 7 баллын бүсэд байрладаг	3
2.4	Газар хөдлөлийн 6 ба түүнээс доош баллын бүсэд байрладаг	1
Гурав. Барилгын хийцлэлийн төвөгшил		
3.1	Онцгой, өндөр төвөгшилтэй	10
3.2	Дунд төвөгшилтэй	5
3.3	Бага төвөгшилтэй	1
Дөрөв. Хөрсний нөхцөл		
4.1	Хөрсний I зэрэг (олон жилийн цэвдэг хөрстэй)	10
4.2	Хөрсний II зэрэг (овойлттой, суулттай, хөөлттэй, устай, нуралттай, гулсамтгай, өгөршсөн хадан хөрстэй)	5
4.3	Хөрсний III зэрэг (энгийн хөрстэй)	1
Тав. Барилгын төлөв байдал		
5.1	Барилга, байгууламжийг ашиглалтад хүлээж аваагүй, баригдаж байгаа барилгууд, ашиглалтын гэрчилгээгүй	10
5.2	Ашиглалтын шаардлага хангахгүй, ашиглалтын улаан өнгийн гэрчилгээтэй	8
5.3	Их засвар, бэхэлгээ, хүчитгэл, шинэтгэл хийх шаардлагатай, ашиглалтын шар өнгийн гэрчилгээтэй	5
5.4	Хэвийн ашиглагдаж байгаа, ашиглалтын ногоон өнгийн гэрчилгээтэй	1
Зургаа. Барилгын насжилт		
6.1	Барилга нь 1970 оноос өмнө ашиглалтад орсон	10
6.2	Барилга нь 1970-1982 онд ашиглалтад орсон	5
6.3	Барилга нь 1983-2002 онд ашиглалтад орсон	3
6.4	Барилга нь 2002 оноос хойш ашиглалтад орсон	1

Үнэлгээ:

30-60 оноо авсан бол их эрсдэлтэй

18-29 оноо авсан бол дунд эрсдэлтэй

17 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

02.2.Барилгын материал үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Бүтээгдэхүүний нэр төрөл, зориулалт		
1.1	Барилгын даацын хийц, материал, эдлэхүүн үйлдвэрлэдэг (портландцемент, төмөр бетон бүтээцийн ган туйван, бетон зуурмаг, даацын бетон, төмөр бетон хийц, эдлэхүүн)	10
1.2	Барилгын ханын материал үйлдвэрлэдэг (тоосго, сийрмэг царууц бетон гүлдмай, ханын бетон гүлдмай)	8
1.3	Барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэдэг (хөөсөн полистирол хавтан, эрдэс хөвөн хавтан)	5
1.4	Барилгын бетон хийц эдлэхүүний дүүргэгч материал үйлдвэрлэдэг (элс, хайрга, дайрга, хөөсөн перлитэн элс хайрга, алевролитэн элс хайрга)	3
1.5	Барилгын цонх, хаалга үйлдвэрлэдэг (модон цонх, хаалга, хуванцар PVC цонх, хаалга)	
Хоёр. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, хамрах хүрээ		
2.1	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын хэмжээнд худалдан борлуулдаг	10
2.2	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг бүс нутгийн хэмжээнд худалдан борлуулдаг	8
2.3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг аймаг, орон нутгийн хэмжээнд худалдан борлуулдаг	5
Гурав. Түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
3.1	Түүхий эд, материалыг хүлээн авах, бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын агуулах, талбай байхгүй	10
3.2	Түүхий эд, материалыг хүлээн авах, бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах агуулах, талбайтай боловч шаардлага бүрэн хангахгүй	5
3.3	Түүхий эд, материалыг хүлээн авах, бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын агуулах, талбайтай	1
Дөрөв. Бүтээгдэхүүний чанарт тавих дотоод хяналт		
4.1	Дотоод хяналтын лабораторигүй	10
4.2	Дотоод хяналтын лабораторитой боловч багаж тоног төхөөрөмж дутуу, иж бүрэн тоноглогдоогүй	5
4.3	Дотоод хяналтын лабораторитой, шинжилгээ туршилтын иж бүрэн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон	1
Тав. Мэргэжлийн инженер техникийн ажиллагсдын хангалт		
5.1	Үйлдвэрлэлийн мэргэжлийн технологич инженер байхгүй, инженер техникийн ажиллагсдаар бүрэн хангагдаагүй	5
5.2	Үйлдвэрлэлийн мэргэжлийн технологич инженертэй, инженер техникийн ажиллагсдаар бүрэн хангагдсан	1
Зургаа. Бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалт		
6.1	Бүтээгдэхүүнээ тохирлын баталгаанд хамруулаагүй, тохирлын гэрчилгээ аваагүй	10
6.2	Бүтээгдэхүүнээ тохирлын баталгаанд хамруулж тохирлын гэрчилгээ авсан	1
Долоо. Өмнөх хяналт шалгалтын түүх		



7.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
7.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
7.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

32-65 оноо авсан бол их эрсдэлтэй
20-31 оноо авсан бол дунд эрсдэлтэй
29-өөс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

02.3.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг.Хот, суурин газрын хүн ам		
1.1	500.0 мянгаас дээш	10
1.2	100.0-500.0 мянга хүртэл	8
1.3	50.0-100.0 мянга хүртэл	7
1.4	20.0-50.0 мянга хүртэл	6
1.5	0.5-20.0 мянга хүртэл	5
1.6	0.5-10.0 мянга хүртэл	4
1.7	0.5 мянгаас доош	2
Хоёр.Хот, суурин газрыг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичиг		
2.1	Тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлгүй	10
2.2	Тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг боловсруулах, тодотгол, шинэчлэлийн ажил хийгдэж байгаа	8
2.3	Тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд тодотгол, шинэчлэлийн ажил хийгдсэн боловч Хот байгуулалтын тухай хуульд заасны дагуу батлагдаагүй	5



2.4.	Тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд, тодотгол, шинэчлэлийн ажил хийгдэж, Хот байгуулалтын тухай хуульд заасны дагуу батлагдсан	1
Гурав.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн боловсруулалт		
3.1	Хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн элемент хот, суурины, бүс нутаг, аймаг, нийслэл, бичил бүсийн хөгжилд эзлэх байр суурь бусад хот, сууринтай харилцан уялдаатай хөгжих нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх зарчим болон тухайн хот, суурины байршил, газарзүйн онцлог, түүхэн хөгжил, байгалийн нөхцөл, нөөц, хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу тухайн хот, суурин газрын нутаг дэвсгэрийн ашиглалтыг тодорхойлон төлөвлөж хүний ажиллаж амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх үндсэн зорилгыг баримталж боловсруулаагүй	10
3.2	Хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн элемент хот, суурины, бүс нутаг, аймаг, нийслэл, бичил бүсийн хөгжилд эзлэх байр суурь бусад хот, сууринтай харилцан уялдаатай хөгжих нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх зарчим болон тухайн хот, суурины байршил, газарзүйн онцлог, түүхэн хөгжил, байгалийн нөхцөл, нөөц, хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу тухайн хот, суурин газрын нутаг дэвсгэрийн ашиглалтыг тодорхойлон төлөвлөж хүний ажиллаж амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх үндсэн зорилгыг баримталж хангалттай тусгаж боловсруулаагүй	5
3.3	Хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн элемент хот, суурины, бүс нутаг, аймаг, нийслэл, бичил бүсийн хөгжилд эзлэх байр суурь бусад хот, сууринтай харилцан уялдаатай хөгжих нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх зарчим болон тухайн хот, суурины байршил, газарзүйн онцлог, түүхэн хөгжил, байгалийн нөхцөл, нөөц, хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу тухайн хот, суурин газрын нутаг дэвсгэрийн ашиглалтыг тодорхойлон төлөвлөж хүний ажиллаж амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх үндсэн зорилгыг баримталж боловсруулсан.	1
Дөрөв.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт		
4.1 Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө		
4.1.1	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгүй	10



4.1.2	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тавигдах шаардлагын дагуу боловсруулан баталсан боловч мөрдөөгүй	9
4.1.3	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тавигдах шаардлагын дагуу боловсруулаагүй	8
4.1.4	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тавигдах шаардлагын дагуу боловсруулсан боловч хуулийн дагуу батлуулаагүй	5
4.1.5	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тавигдах шаардлагын дагуу боловсруулан батлуулсан	4
4.1.6	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тавигдах шаардлагын дагуу боловсруулан батлуулсан боловч мөрдөөгүй	5
4.2 Хот, суурины эдэлбэр газрын бүсчлэл		
4.2.1	Хот, суурины нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлагыг зөрчиж газар олгон барилгажуулсан	10
4.2.2	Хот, суурины нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлагыг зөрчиж барилгажуулсан	8
4.2.3	Хот, суурины нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлагыг хангасан	1
4.3 Хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах		
4.3.1	Дараах бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоогоогүй. -Түүх, соёлын дурсгалт барилга, байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд; -Усны эх үүсвэр, усан сан бүхий газрын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд; -Ашигт малтмалын орд бүхий бүсэд; -Байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай бүсэд; -Экологийн онцгой болон сүйрлийн бүсэд; -Газар дээрх болон доорх дэд бүтэц бүхий бүс.	10
4.3.2.	Дараах бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон боловч мөрдөж ажилладаггүй. -Түүх, соёлын дурсгалт барилга, байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд; -Усны эх үүсвэр, усан сан бүхий газрын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд; -Ашигт малтмалын орд бүхий бүсэд; -Байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай бүсэд; -Экологийн онцгой болон сүйрлийн бүсэд; -Газар дээрх болон доорх дэд бүтэц бүхий бүс.	8



4.3.3.	Дараах бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон. -Түүх, соёлын дурсгалт барилга, байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд; -Усны эх үүсвэр, усан сан бүхий газрын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд; -Газар дээрх болон доорх дэд бүтэц бүхий бүс.	5
4.3.4.	Дараах бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоож, мөрдөж ажилладаг. -Түүх, соёлын дурсгалт барилга, байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд; -Усны эх үүсвэр, усан сан бүхий газрын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд; -Ашигт малтмалын орд бүхий бүсэд; -Байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай бүсэд; -Экологийн онцгой болон сүйрлийн бүсэд; -Газар дээрх болон доорх дэд бүтэц бүхий бүс.	1

Үнэлгээ:

45-90 оноо авсан бол их эрсдэлтэй

27-44 оноо авсан бол дунд эрсдэлтэй

26 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

02.4. Инженерийн байгууламж, шугам сүлжээг (цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, халаалт, агаар сэлгэлтийн барилга, байгууламж, шугам сүлжээ) эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Барилгын зориулалт		
1.1	Төрийн тусгай хамгаалалтын, цахилгаан, дулаан, цэвэр усны эх үүсвэр, улс орны стратегийн онцгой ач холбогдол бүхий үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламж болон түүний шугам сүлжээ	10
1.2	Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууц, үзвэр, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламж болон түүний шугам сүлжээ	8
1.3	Бусад (түр барилга байгууламж гэх мэт)	1
Хоёр. Хүчин чадал		
2.1	Их (5 МВт болон 5000 м ³ /хоног, түүнээс дээш)	10
2.2	Дунд (3-5 МВт болон 3000-5000 м ³ /хоног хүртэл)	5
2.3	Бага (3 МВт хүртэл, 3000 м ³ /хоногоос доош)	3
Гурав. Барилгын хийцлэлийн төвөгшил		
3.1	Онцгой, өндөр төвөгшилтэй	10



3.2	Дунд төвөгшилтэй	5
3.3	Бага төвөгшилтэй	1
Дөрөв. Тоног төхөөрөмжийн насжилт		
4.1	Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан	10
4.2	Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа 50 хувиас дээш	5
4.3	Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа 20-50 хувьтай	3
4.4	Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа 20 хувьд хүрээгүй	0
Тав. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас		
5.1	Шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчилтэй (хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, орон сууц, гэр хашаа барьсан, ойр орчимд хэрэглэгч олонтой, хамгаалалтын зурвас зөрчсөн хэрэглэгчдийг удаа дараа нүүлгэн шилжүүлж байсан тохиолдлууд гарч байсан, шугам сүлжээ эзэмшигчийн зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан гэх мэт)	10
5.2	Шугам сүлжээний зурвасын зөрчилгүй	0
Зургаа. Хэрэглэгчийн зэрэглэл		
6.1	1-р зэрэглэлийн хэрэглэгч	10
6.2	2-р зэрэглэлийн хэрэглэгч	5
6.3	3-р зэрэглэлийн хэрэглэгч	1
Долоо. Өмнөх хяналт шалгалтын түүх		
7.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
7.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
7.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	0
<p>Үнэлгээ:</p> <p>35-70 оноо авсан бол их эрсдэлтэй</p> <p>21-34 оноо авсан бол дунд эрсдэлтэй</p> <p>20 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй</p>		
<p>02.5. Өргөх байгууламж үйлдвэрлэдэг, ашигладаг этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт</p>		
№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Өргөх байгууламжийн зориулалт		
1.1	Хүн өргөх зориулалтаар ашиглагдаж байгаа улсын бүртгэлд бүртгэдэг бүх төрлийн хүн зөөвөр, хүн зөөвөр-ачаа, эмнэлгийн зориулалттай лифт болон эскалатор	10
1.2	Бүх төрлийн ачааг өргөдөг кран, барилгын өргүүр, автовышка, кран-манипулятор	
1.3	Цанын баазад ашиглагдаж байгаа улсын бүртгэлд бүртгэгддэг бүх төрлийн уулын ган татлагат чирдэг болон дүүжин зам	
1.4	Далд уурхайд хүн ба ачаа өргөх зориулалтаар ашиглагддаг өргөх байгууламж	

1.5	Бага овор, даац бүхий бусад бүх төрлийн таль, өргүүр, домкрат, ачааны лифт зэрэг ачаа өргөх зориулалттай төхөөрөмжүүд	5
1.6	Нисэх онгоцны буудал, үйлчилгээний газар ашиглагдах урсдаг зам	1
Хоёр. Өргөх байгууламжийн төрөл, хүчин чадал		
2.1	Бүх төрлийн 100 кг ба түүнээс дээш даацтай лифт болон 2.2-2.8 зааснаас бусад бүх төрөл даацтай ачаа өргөх байгууламжууд	10
2.2	10 тн хүртэл даацтай (10 тн-ыг оролцуулан), кранд зүүсэн шалнаас удирддаг зөөврийн товчлуурт, эсхүл суурин самбараас удирдлагатай гүүрэн болон консолкран	
2.3	Угсарч байгаа байгууламж дээр суурилагдсан шорог, цамхаг, яндан хоолой зэргийг угсрах зориулалттай зөөврийн кран	
2.4	1 тн хүртэл даацтай сумт кран (1тн-ыг оролцуулан)	
2.5	Эргэх механизмаар тоноглогдоогүй, тогтмол өнгийлттэй сумт кран	5
2.6	Сургалтын зориулалтаар дадлагын талбайд байрлуулсан гүүрэн, цамхагт кран	
2.7	Экскаватор, бутлан ангилагч ачигч төхөөрөмж, овоолгын болон бусад технологийн зориулалтаар зөвхөн тухайн машиныг засварлах зориулалттай кран	
2.8	Зөвхөн ачаа өргөх зориулалттай өргүүр	1
Гурав. Өргөх байгууламжийн бүлгийн ангилал (MNS ISO 4301/1)		
3.1	Хэт хүнд, эсхүл хүнд нөхцөлд ажилладаг өргөх байгууламж (kp=0.5; kp=1.0)	10
3.2	Дунд нөхцөлд ажилладаг өргөх байгууламж (kp=0.25)	5
3.3	Хөнгөн нөхцөлд ажилладаг өргөх байгууламж (kp=0.125)	1
Дөрөв. Өргөх байгууламжийн насжилт		
4.1	Өргөх байгууламжийн ашиглалтын хугацаа дууссан	10
4.2	Өргөх байгууламжийн ашиглалтын хугацаа 50 хувиас дээш	5
4.3	Өргөх байгууламжийн ашиглалтын хугацаа 50 хувьд хүрээгүй	1
Тав. Тусгай зөвшөөрлийн шаардлага		
5.1	Тусгай зөвшөөрөл шаарддаг үйлчилгээ	10
5.2	Тусгай зөвшөөрөл шаардлагагүй үйлчилгээ	5
Зургаа. Дотоод хяналт		
6.1	Аюулгүй ажиллагаа, хяналт, ашиглалт, бүрэн байдал хариуцсан инженер, техникийн ажилтан байхгүй	10
6.2	Оператор, кранчин, оосорлогч, лифтчин зэрэг мэргэжлийн үнэмлэхтэй ажилчдаар хангагдаагүй	
6.3	Инженер, техникийн болон мэргэжлийн ажилтнаар хангагдсан	1
Долоо. Өргөх байгууламжийн магадлал		
7.1	Техникийн бүрэн магадлалд ороогүй	10
7.2	Техникийн ээлжит магадлалд ороогүй	
7.3	Магадлал хийлгэх хугацаа хэтэрсэн	5
7.4	Магадлал хийлгэсэн	1
Найм. Өргөх төхөөрөмжийн засвар үйлчилгээ		
8.1	Тухайн орон нутагт өргөх төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх мэргэжлийн газаргүй	10
8.2	Тухайн орон нутагт өргөх төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх мэргэжлийн газартай	1
Ес. Өмнөх хяналт шалгалтын түүх		



9.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
9.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
9.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

35-70 оноо авсан бол их эрсдэлтэй

21-34 оноо авсан бол дунд эрсдэлтэй

20 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

02.6.Газрын нөөц ашиглалт, өмчлөгч, эзэмшигч, ашиглагч этгээдийг газар, түүний хөрсөнд сөрөг нөлөөлөл үзүүлэх байдлаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Олгогдсон газрын талбайн хэмжээ		
1.1	1.6 га ба түүнээс дээш	10
1.2	0.08-1.5 га хүртэл	5
1.3	0.07 га ба түүнээс доош	1
Хоёр. Олгогдсон газрын зориулалт		
2.1	Уул уурхайн олборлолт, эдэлбэрийн үйлдвэрлэлийн газар, бүх төрлийн үйлдвэрлэл, химийн хорт бодис, арьс шир, ноос, ноолуурын үйлдвэр, цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр, төмөр зам, нисэх онгоцны буудлын барилга, инженерийн шугам сүлжээ, түүний дэд бүтэц, хамгаалалтын бүс, нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, худалдаа, бүх төрлийн үйлчилгээ, нийтийн зориулалттай орон сууц, газар тариалан	10
2.2	Төсөвт байгууллага, бүх төрлийн авто зогсоол, нийтийн эдэлбэр газар, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, шашин, сүм хийд, хөдөө аж ахуйн газар	5
2.3	Гэр бүлийн хамтын хэрэгцээ	3
Гурав. Олгогдсон газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулсан эсэх		
3.1	Ашиглуулдаг	10
3.2	Ашиглуулдаггүй	3
Дөрөв. Тухайн орчинд үзүүлэх бохирдлын цар хүрээ		
4.1	Агаар, хөрс, усыг зэрэг бохирдуулдаг	10
4.2	Аль нэгийг нь илүү бохирдуулдаг	5
4.3	Алийг нь ч бохирдуулахгүй	1

Тав. Газрын зориулалт, хөрсний бохирдлын стандартын түвшин		
5.1	Хөрсийг их хэмжээгээр бохирдуулах, эсхүл элэгдэл, эвдрэлд оруулах эрсдэлтэй үйл ажиллагаа (Уул уурхайн олборлолт, эдэлбэрийн үйлдвэрлэлийн газар, бүх төрлийн үйлдвэрлэл, химийн хорт бодис, арьс шир, ноос, ноолуурын үйлдвэр, цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр, төмөр зам, нисэх онгоцны буудлын барилга, инженерийн шугам сүлжээ, түүний дэд бүтэц, хамгаалалтын бүс, нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, худалдаа, бүх төрлийн үйлчилгээ, нийтийн зориулалттай орон сууц, газар тариалан) явуулдаг	10
5.2	Хөрсийг дунд хэмжээгээр бохирдуулах эрсдэлтэй үйл ажиллагаа (Төсөвт байгууллага, бүх төрлийн авто зогсоол, нийтийн эдэлбэр газар, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, шашин, сүм хийд, хөдөө аж ахуйн газар) явуулдаг	5
5.3	Хөрсийг бага бохирдуулах үйл ажиллагаа явуулдаг (гэр бүлийн хамтын хэрэгцээ)	1
Зургаа. Үйлдвэрлэл, үйлчилгээний байршил		
6.1	Хүн амын суурьшлын бүс, тусгай хамгаалалттай газар нутаг, инженерийн шугам сүлжээ, үер усны ам, далан, тэсрэх материалын агуулах, ой, ус, ундны усны эрүүл ахуй, ариун цэврийн гэх мэт хамгаалалтын болон хязгаарлалтын бүсэд үйл ажиллагаа явуулдаг	10
6.2	Зөвшөөрөгдсөн үйлдвэрийн бүсэд байрладаг, эсхүл инженерийн шугам сүлжээ, үер усны ам, далан, тэсрэх материалын агуулах, ой, ус, ундны усны эрүүл ахуй, ариун цэврийн гэх мэт хамгаалалтын болон хязгаарлалтын бүсэд үйл ажиллагаа явуулдаггүй	5
Долоо. Хамгаалалтын бүс (зурвас) тогтоосон байдал		
7.1	Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаалалтын бүс тогтоогоогүй	10
7.2	Хамгаалалтын бүс тогтоосон ч газар дээр нь тэмдэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй	8
7.3	Хамгаалалтын бүс тогтоож газар дээр нь тэмдэгжүүлэх арга хэмжээ авч ажилласан, эсхүл хууль тогтоомжид бүс тогтоох заалт байхгүй	1
Найм. Уул уурхай болон бусад тээвэрлэлт		
8.1	Шороон замтай	10
8.2	Сайжруулсан замтай	7
8.3	Хатуу хучилттай замтай	4
8.4	Төмөр замтай	1
Ес. Газрын нөхөн сэргээлт, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах түвшин		
3.1	Галын аюулгүйн зай хэмжээний зөрчилтэй (үерийн усны далан, сувагт байрласан, гэр хороолол ба хатуу түлшээр халаадаг байр, орон сууц, олон нийтийн барилга, байгууламжид ойр байрладаг гэх мэт)	10
3.2	Технологийн байгууламжийн дотоод зай хэмжээний зөрчилтэй	5
3.3	Галын аюулгүйн зай хэмжээний зөрчилгүй	1
Дөрөв. Технологийн шийдэл		
4.1	Технологийн байгууламжаас асгарсан газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон усыг цуглуулах, хадгалах, ууршуулах, цэвэрлэх байгууламжгүй	10
4.2	Технологийн байгууламжаас асгарсан газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон усыг цуглуулах, хадгалах, ууршуулах, цэвэрлэх байгууламжтай	1
Тав. Нөөцлөх савны байрлал		
5.1	Сав ил байрладаг	10
5.2	Сав хагас далд байрладаг	5
5.3	Сав далд байрладаг	3
Зургаа. Нөөцлөх савны насжилт		
6.1	Хана, шал, дээврийн металлын зузааны нимгэрэлт 25 хувиас дээш	10
6.2	Хана, шал, дээврийн металлын зузааны нимгэрэлт 11-24 хувь	5
6.3	Хана, шал, дээврийн металлын зузааны нимгэрэлт 10 хүртэл хувь	3
6.4	Хана, шал, дээврийн металлын зузааны нимгэрэлтгүй	1
Долоо. Хадгалах савны бүртгэл		
7.1	Шатахуун хадгалах сав, хий хадгалах даралтат савыг улсын бүртгэлд хамруулж ашиглах зөвшөөрөл аваагүй	10



7.2	Шатахуун хадгалах сав, хий хадгалах даралтат савыг улсын бүртгэлд хамруулж ашиглах зөвшөөрөл авсан	1
Найм. Аюулгүйн тоног төхөөрөмж		
8.1	Шүүрэлт, гоожилтыг мэдрэх, таслан зогсоох төхөөрөмжгүй	10
8.2	Шүүрэлт, гоожилтыг мэдрэх, таслан зогсоох механик төхөөрөмжтэй	5
8.3	Шүүрэлт, гоожилтыг мэдрэх, таслан зогсоох бүрэн автомат төхөөрөмжтэй	1
Ес. Гал түймрээс урьдчилан сэргийлэх систем		
9.1	Гал унтраах тоног төхөөрөмжгүй	10
9.2	Гал унтраах хөдөлгөөнт болон механик тоног төхөөрөмжтэй	5
9.3	Гал унтраах бүрэн автомат тоног төхөөрөмжтэй	1
Арав. Гал түймэр, осол гарсан байдал		
10.1	Сүүлийн 2 жилд гал түймэр, техникийн аваарь, осол гарсан	10
10.2	Гал түймэр, техникийн аваарь, осол гарсан	5
10.3	Гал түймэр, техникийн аваарь, осол гараагүй	1
Арван нэг. Мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдын хангалт		
11.1	Мэргэжлийн инженер, техникийн ажилтан байхгүй	10
11.2	Инженер, техникийн ажилтнуудын 50-аас бага хувь нь мэргэжлийн боловсролтой (дээд болон курс, дамжаа гэх мэт)	5
11.3	Инженер, техникийн ажилтнуудын 50-аас дээш хувь нь дээд мэргэжлийн боловсролтой	1
Арван хоёр. Дотоод хяналт		
12.1	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтныг томилоогүй	10
12.2	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтантай боловч дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулдаггүй	8
12.3	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтантай, дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулдаг	1
Арван гурав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
13.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
13.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
13.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг бүрэн биелүүлж ажилладаг.	1

Үнэлгээ:

55-110 оноо авсан бол их эрсдэлтэй

34-54 оноо авсан бол дунд эрсдэлтэй

33 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

---o0o---



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 195 дугаар
тогтоолын 7 дугаар хавсралт

**07.ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ОБЪЕКТЫГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД
ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

№	Чиглэл	Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын нэр, код
1	Хөдөлмөрийн хяналт,	07.1. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцогч этгээдийг хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын үйл ажиллагаагаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
2	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналт,	07.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагаагаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
3	Нийгмийн хамгааллын хяналт	07.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг ажилтны нийгмийн хамгааллын үйл ажиллагаагаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт



07.1. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцогч этгээдийг хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын үйл ажиллагаагаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Салбарын эрсдэлийн түвшин		
1.1	Үйлдвэрлэлийн осол, гэмтлийн тоо өндөртэй салбар	10
1.2	Үйлдвэрлэлийн осол, гэмтлийн тоо дунд салбар	8
1.3	Үйлдвэрлэлийн осол, гэмтэл гараагүй салбар	1
Хоёр. Үйлдвэрлэлийн осол бүртгэгдсэн байдал		
2.1	Бүлэг болон хүний амь нас хохирсон үйлдвэрлэлийн осол бүртгэгдсэн	10
2.2	Хүнд болон хөнгөн хэлбэрийн үйлдвэрлэлийн осол бүртгэгдсэн	8
2.3	Үйлдвэрлэлийн осол бүртгэгдээгүй	1
Гурав. Өргөдөл, гомдол		
3.1	Хууль тогтоомж зөрчсөн асуудлаар удаа дараа өргөдөл, гомдол ирсэн	10
3.2	Хууль тогтоомж зөрчсөн асуудлаар өргөдөл, гомдол ирсэн	5
3.3	Хууль тогтоомж зөрчсөн асуудлаар өргөдөл, гомдол ирээгүй	1
Дөрөв. Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал		
4.1	Суурин, том оврын, 380В-оос дээш хүчдэл хэрэглэдэг, өргөх зөөх хүнд даацын механизм, зуух, даралтат сав ашигладаг	10
4.2	Суурин, бага оврын механизм ашигладаг	5
4.3	Бусад	1
Тав. Ажиллах хүч, нийт ажилтны тоо		
5.1	Ажилтны тоо 50-аас дээш	10
5.2	Ажилтны тоо 20-49 бол	5
5.3	Ажилтны тоо 1-19 бол	1
Зургаа. Хөдөлмөр эрхлэлтийн байдал		
6.1	Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл 2 ба түүнээс дээш туслан гүйцэтгэгчтэй аж ахуйн нэгж, байгууллага	10
6.2	Бусад	1
Долоо. Өмнөх хяналт шалгалтын түүх		
7.1	Өмнө хийсэн хяналт, шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
7.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5



7.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
Найм. Дотоод хяналт		
8.1	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтангүй, дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулдаггүй	10
8.2	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтантай боловч дотоод хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаггүй	5
8.3	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтантай, дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцдог	1

Үнэлгээ:

40-80 оноо авсан бол их эрсдэлтэй
24-39 оноо авсан бол дунд эрсдэлтэй
23 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

07.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагаагаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигладаг химийн бодис		
1.1	Монгол Улсад хэрэглэхийг хязгаарласан, хорт хавдар үүсгэдэг, үр удамд нөлөөлдөг, нөхөн үржихүүд хортой химийн бодис ашигладаг	10
1.2	1.1-д зааснаас бусад химийн бодис ашигладаг	5
1.3	Үйлдвэрлэл, үйлчилгээнд химийн бодис ашигладаггүй	1
Хоёр. Ажлын бүсийн агаар дахь тоосны фракц хэмжээ		
2.1	Үйлдвэрлэлийн явцад цулцанд нэвтэрдэг (4мкм хүртэл хэмжээтэй) тоос үүсдэг ажил хийгддэг	10
2.2	Үйлдвэрлэлийн явцад 5 мкм -100 мкм хүртэл хэмжээтэй тоос үүсдэг ажил хийгддэг	7
2.3	Үйлдвэрлэлийн явцад 100 мкм-аас дээш хэмжээтэй тоос үүсдэг ажил хийгддэг	5
2.4	Тоос үүсгэдэг ажил байхгүй	1
Гурав. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, шинжилгээ, үнэлгээ		
3.1	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, шинжилгээ, үнэлгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагаар хийлгээгүй	10
3.2	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, шинжилгээ, үнэлгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагаар хийлгэсэн боловч холбогдох арга хэмжээ авдаггүй	5
3.3	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, шинжилгээ, үнэлгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагаар хийлгэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн	1
Дөрөв. Тоног төхөөрөмжийн шуугиан, доргион		
4.1	Шуугиан, доргион үүсгэгч тоног төхөөрөмж ашигладаг	10
4.2	Шуугиан, доргион үүсгэгч тоног төхөөрөмж ашигладаггүй	1



Тав. Ажлын байр		
5.1	Гоц халдвартай материал, өсгөвөртэй харьцан ажилладаг, газрын дор, хязгаарлагдмал болон халуун орчин, гадаа, ил задгай нөхцөл, өндөрт ажиллах, ионжуулагч биш цацрагийн нөлөө бүхий ажлын байртай	10
5.2	5.1-д заасан ажлын байрнаас бусад	1
Зургаа. Химийн бодис, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин		
6.1	Химийн бодисын хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин бүртгэгдсэн	10
6.2	Химийн бодисын хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин бүртгэгдээгүй	1
Долоо. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц		
7.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэцгүй, ажилтангүй (төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллагад хавсран ажилладаг ажилтангүй), эрүүл ахуйчгүй, эмчгүй	10
7.2	Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан нь эрүүл ахуйн асуудлыг хариуцан ажилладаг, мэргэжлийн бус эрүүл ахуйчтай, эмчтэй	5
7.3	Мэргэжлийн хөдөлмөрийн эрүүл ахуйчтай, эмчтэй, төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллагад хавсран ажилладаг ажилтантай	1
Найм. Дотоод хяналт		
8.1	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтангүй, дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулдаггүй	10
8.2	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтантай боловч дотоод хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаггүй	5
8.3	Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтантай, дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцдог	1
Ес. Өмнөх хяналт шалгалтын түүх		
9.1	Өмнө хийсэн хяналт, шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй, үйлдвэрлэлийн чиглэлээр шинээр байгуулагдсан болон сүүлийн 5 жилд хяналт шалгалтад хамрагдаагүй	10
9.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
9.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

40-90 оноо авсан бол их эрсдэлтэй,
24-39 оноо авсан бол дунд эрсдэлтэй,
23 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй



07.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг ажилтны нийгмийн хамгааллын үйл ажиллагаагаар эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын хамрагдалт		
1.1	Нийгмийн даатгалд бүртгэлгүй, шимтгэл хураамж төлдөггүй	10
1.2	Нийгмийн даатгалд бүртгэлтэй боловч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож шимтгэл, хураамж төлсөн	5
1.3	Нийгмийн даатгалд бүртгэлтэй, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг бүрэн тайлагнаж, шимтгэл хураамж төлдөг	1
Хоёр. Даатгуулагчийн нийгмийн даатгалд хамрагдалт		
2.1	Ажилтнуудыг нийгмийн даатгалд бүрэн хамруулаагүй	10
2.2	Ажилтнуудын 50 хүртэлх хувийг нийгмийн даатгалд хамруулсан	5
2.3	Ажилтнуудыг нийгмийн даатгалд бүрэн хамруулсан	1
Гурав. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр		
3.1	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр 3 сараас дээш хугацаагаар хуримтлагдсан	10
3.2	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр 1-3 сар хүртэлх хугацаагаар хуримтлагдсан	5
3.3	Шимтгэлийг сар бүр төлсөн, хуримтлагдсан өргүй	1
Дөрөв. Дотоод хяналт		
4.1	Дотоод хяналтын нэгж/ажилтангүй	10
4.2	Дотоод хяналтын нэгж/ажилтантай боловч, үйл ажиллагаа хэвшээгүй	5
4.3	Дотоод хяналтын нэгж /ажилтантай, үйл ажиллагаа хэвшсэн	1
Тав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
5.1	Өмнө хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
5.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
5.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

25-50 оноо авсан бол их эрсдэлтэй

15- 24 оноо авсан бол дунд эрсдэлтэй

14 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

---о0о---

Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 195 дугаар
тогтоолын 8 дугаар хавсралт

**08.ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОБЪЕКТЫГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД
ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

**08.1. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд
хамааруулах шалгуур, үзүүлэлт**

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Хүнсний бүтээгдэхүүний төрөл		
1.1	Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, бялуу, бялуун бүтээгдэхүүн, нялх, балчир хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэр, нөөшилсөн даршилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	10
1.2	Төрөл бүрийн чихэр, чихрэн бүтээгдэхүүн, шоколад, зөгийн балны үйлдвэрлэл, савласан цэвэр ус, рашаан, төрөл бүрийн ундаа, шүүс, шингэн цайны үйлдвэрлэл, гурил, давсны үйлдвэр, жижиглэн савлагааны болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	5
1.3	Үр тариа, ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн талх, төрөл бүрийн шанз, кремгүй бусад гурилан бүтээгдэхүүн, спирт, согтууруулах ундааны үйлдвэр, хуурай цай, тамхи бусад хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1
Хоёр. Үйлдвэрлэлийн хүчин чадал		
2.1	Хоногт 3.1 тонноос илүү бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	10
2.2	Хоногт 0.5–3 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	5
2.3	Хоногт 0.5 тонноос бага хэмжээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	1
Гурав. Үйлдвэрлэлийн барилга, байгууламж		
3.1	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаж, өргөтгөөгүй, үйлдвэрлэлийн барилга, байгууламжийг эрх бүхий байгууллага ашиглалтад хүлээн аваагүй, хууль тогтоомж, техникийн зохицуулалтад нийцээгүй зориулалтын бус үйлдвэрлэлийн байртай	10
3.2	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, үйлдвэрлэлийн технологи, хүчин чадал, техникийн зохицуулалтад нийцсэн барилга, байгууламжтай	5
3.3	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, үйлдвэрлэлийн технологи, хүчин чадал, техникийн зохицуулалтад нийцсэн барилга, байгууламжтай	1
Дөрөв. Цэвэр усан хангамж, бохир ус зайлуулах татуургын систем		
4.1	Үйлдвэр, цехийн барилга, байгууламж нь төвлөрсөн болон хэсгийн системд холбогдоогүй	10
4.2	Үйлдвэр, цех нь хэсгийн системд холбогдсон	5
4.3	Үйлдвэр, цехийн барилга, байгууламжийн инженерийн шугам сүлжээ нь төвлөрсөн системд холбогдсон	1
Тав. Үйлдвэрлэлийн шугам, тоног төхөөрөмж		



5.1	Хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь ажилчдаас хамаарсан механик ажиллагаа ихтэй	10
5.2	Үйлдвэрлэлийн шугам, тоног төхөөрөмж нь хагас автоматажсан бүтээгдэхүүний савлалт нь механик ажиллагаатай	5
5.3	Бүрэн автомат шугамтай, компьютержсон	1
Зургаа. Түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
6.1	Хүнсний түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүн, сав баглаа, боодлын төрөлжсөн агуулахгүй	10
6.2	Хүнсний түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, сав баглаа, боодлын төрөлжсөн агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдаагүй, эсхүл төрөлжсөн агуулахгүй боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгслээр хангагдсан	5
6.3	Хадгалалтын горим, нөхцөл шаардлагыг хангасан хүнсний түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүн, сав баглаа боодлын төрөлжсөн агуулах, тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн хангагдсан	1
Долоо. Тээвэрлэлтийн нөхцөл		
7.1	Үйлдвэрлэлийн тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
7.2	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй боловч шаардлага хангаагүй (хөргүүр ажилладаггүй, хаалга нь бүрэн хаагддаггүй хэвийн бус ажиллагаатай)	5
7.3	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй	1
Найм. Хүнсний үйлдвэрлэлийн хүний нөөц		
8.1	Мэргэжлийн мэргэшсэн ажилтнаар хангагдаагүй	10
8.2	Гэрээт мэргэжлийн ажилтантай	5
8.3	Мэргэжлийн мэргэшсэн хүний нөөцтэй	1
Ес. Үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлсэн байдал		
9.1	Зохистой дадлыг нэвтрүүлээгүй	10
9.2	Зохистой дадлыг нэвтрүүлсэн боловч дагаж мөрддөггүй	5
9.3	Зохистой дадлыг бүрэн нэвтрүүлсэн мөрдөж ажилладаг	1
Арав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
10.1	Зөрчил, дутагдлыг арилгах тодорхой арга хэмжээ авдаггүй, хууль тогтоомж, техникийн зохицуулалтыг зөрчсөн зөрчил дутагдал нь давтагдан гарч байдаг	10
10.2	Хууль тогтоомж, техникийн зохицуулалтыг анх удаа зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаарх арга хэмжээг хэрэгжүүлдэг	5
10.3	Хууль тогтоомж, техникийн зохицуулалтын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
<p>Үнэлгээ:</p> <p>50-100 оноо авсан бол их эрсдэлтэй</p> <p>25-49 оноо авсан бол дунд эрсдэлтэй</p> <p>24 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй</p>		

08.2.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Хоол үйлдвэрлэлийн хүчин чадал		
1.1	501-ээс дээш порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	10
1.2	51-500 порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	5
1.3	50-аас доош порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	1
Хоёр. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт		
2.1	Эмнэлэг, сувилал, ахмад настны болон нярай, бага насны хүүхдийн асрамжийн байгууллага, хүүхдийн зуслан, цэцэрлэг, сургууль, сургуулийн дотуур байр, цэргийн анги, хорих газрын хоолны газар, төмөр зам, онгоцоор зорчигчдод зориулсан, хүлээн авалт болон арга хэмжээ катерингийн, үйлдвэр, албан байгууллагын дэргэдэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй бол	10
2.2	Бусад хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар	5
Гурав. Ажлын байрны нөхцөл		
3.1	Батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, зориулалтын бус байртай	10
3.2	Зориулалтын бус байрыг өөрчлөн засварласан	5
3.3	Батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, зориулалтын байртай	1
Дөрөв. Цэвэр усны хангамж		
4.1	Хоолны газрын барилга, байгууламж нь инженерийн төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй	10
4.2	Хоолны газрын шугам сүлжээ нь хэсгийн холболттой	5
4.3	Хоолны газрын барилга, байгууламж нь инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Тав. Бохир ус зайлуулах татуургын систем		
5.1	Бохир ус зайлуулах шугамгүй (зөөврийн)	10
5.2	Стандартын шаардлага хангасан бохир усны цооногтой	5
5.3	Бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Зургаа. Халаалтын систем		
6.1	Энгийн галлагаатай	10
6.2	Хэсгийн халаалтын системтэй бол галлагааны хэсэг тусдаа, шаардлага хангасан утаагүй түлш хэрэглэдэг.	5
6.3	Халаалт нь төвлөрсөн системд холбогдсон	1
Долоо. Агааржуулалтын систем		
7.1	Агааржуулалтын системгүй	10
7.2	Агааржуулалтын системтэй боловч шаардлага хангаагүй	5
7.3	Хүчин чадалдаа тохирсон агаар сэлгэх хоолой бүхий агааржуулалтын системтэй (Инженерийн зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн)	1
Найм. Хүнс, түүхий эдийн тээвэрлэлтийн нөхцөл		
8.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
8.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч хүнсний бүтээгдэхүүнийг дам бохирдол үүсэхээс сэргийлсэн нөхцөлд тээвэрлэхээр тоногдсон тээврийн хэрэгсэл ашигладаг	5
8.3	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй	1
Ес. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		



9.1	Хүнсний бүтээгдэхүүний стандартын шаардлага хангасан агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	10
9.2	Хүнсний бүтээгдэхүүний стандартын шаардлага хангасан агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгслээр хангагдаагүй	5
9.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан агуулах, тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн хангагдсан	1
Арав. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүний нөөц		
10.1	Мэргэжлийн мэргэшсэн ажилтнаар хангагдаагүй	10
10.2	Мэргэжлийн мэргэшсэн ажилтан ажиллагсадгүй боловч сургалтад хамрагдсан мэргэжлийн бөгөөд мэргэжлийн сургалтад хамрагдсан үнэмлэхтэй мэргэшсэн ажилтныг гэрээгээр ажиллуулдаг	5
10.3	Мэргэжлийн мэргэшсэн хүний нөөцтэй	1
Арван нэг. Хоолны гаралтай хордлого, хордлогот халдвар гарсан байдал		
11.1	Тухайн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт хоолны гаралтай хордлого, хордлогот халдвар сүүлийн 3 жилд гарсныг хяналт шалгалтын байгууллага шалгаж тогтоосон	10
11.2	Хоол хүнснээс гаралтай хордлого, хордлогот халдвар илэрсэн талаарх санал, гомдол сүүлийн 2 жилд гарч байсан	5
11.3	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт хоолны гаралтай хордлого, хордлогот халдвар гараагүй	1
Арван хоёр. Өмнөх хяналт шалгалтын түүх		
12.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
12.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
12.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
Арван гурав. Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байдал		
13.1	Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй	10
13.2	Дотоод хяналтын алба/ажилтантай боловч, үйл ажиллагаа хэвшээгүй	5
13.3	Дотоод хяналт тогтмолжсон	1

Үнэлгээ:

65-130 оноо авсан бол их эрсдэлтэй
39-64 оноо авсан бол дунд эрсдэлтэй
38 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

08.3.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, худалдаалалтын үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

(Хүнсний чанар, стандартын хяналт, Мал эмнэлгийн хяналт, Ургамал хамгааллын хяналт)

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Худалдааны газар, агуулахын ажлын байрны нөхцөл		
1.1	Худалдааны газар, агуулах нь батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, технологийн урсгалыг зөв зохион байгуулаагүй	10
1.2	Худалдааны газар, агуулах нь батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй боловч технологийн урсгалыг зөв зохион байгуулсан	5
1.3	Худалдааны газар, агуулах нь батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, технологийн урсгалыг зөв зохион байгуулсан	1
Хоёр. Усан хангамжийн нөхцөл		
2.1	Барилга, байгууламж нь инженерийн төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбоогүй, зөөврийн усан хангамжтай	10
2.2	Барилга, байгууламжийн шугам сүлжээ нь хэсгийн шугам сүлжээнд холбогдсон	5
2.3	Барилга, байгууламж нь инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Гурав. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
3.1	Стандартын шаардлага хангасан агуулахгүй, хүнсийг горимын дагуу хадгалах шаардлага хангасан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлгүй	10
3.2	Стандартын шаардлага хангасан агуулахтай боловч хүнсийг горимын дагуу хадгалах шаардлага хангасан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр хангагдаагүй	5
3.3	Стандартын шаардлага хангасан агуулах, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр бүрэн хангагдсан	1
Дөрөв. Тээвэрлэлтийн нөхцөл		
4.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
4.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч хүнсний бүтээгдэхүүнийг дам бохирдол үүсэхээс сэргийлсэн нөхцөлд тээвэрлэхээр тоногдсон тээврийн хэрэгсэл ашигладаг, эсхүл гэрээт байгууллагаар тээвэрлүүлдэг	5
4.3	Зориулалтын, хөргүүртэй тээврийн хэрэгсэлтэй	1
Тав. Цэвэрлэгээ, халдваргүйтгэл		
5.1	Цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийгддэггүй, шавж, мэрэгч амьтан үржих, үүрлэх нөхцөл бүрдсэн	10
5.2	Цэвэрлэгээ, халдваргүйтгэл тогтмол хийгддэггүй, шавж, мэрэгч амьтан үржих, үүрлэхээс сэргийлэх арга хэмжээ авдаг боловч дотоод хяналт тавьдаггүй	5
5.3	Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гэрээгээр халдваргүйтгэл тогтмол хийлгэдэг, эсхүл тухайн байгууллага зааврын дагуу устгалыг хийдэг, шавж, мэрэгч амьтан үржих, үүрлэх нөхцөлөөс бүрэн хамгаалсан	1



Зургаа. Дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлсэн байдал		
6.1	Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй	10
6.2	Дотоод хяналтын алба/ажилтантай боловч, үйл ажиллагаа хэвшээгүй	5
6.3	Дотоод хяналт тогтмолжсон	1
Долоо. Өмнөх хяналт шалгалтын түүх		
7.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
7.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
7.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

- 35-70 оноо авсан бол их эрсдэлтэй
- 21-34 оноо авсан бол дунд эрсдэлтэй
- 20 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

(Жич: Мал амьтны гаралтай түүхий эдийн агуулах, захад мал эмнэлгийн хяналтын байцаагч энэ шалгуураар бүртгэлжүүлнэ)

08.4.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний биоаюулгүй байдлыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг.Бүтээгдэхүүний хаяг, шошгод тавигдах шаардлага		
1.1	Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний бүтээгдэхүүний шошгод хувиргасан амьд организмаас гаралтай эсэхийг тусгасан	10
Хоёр.Үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүнд тавигдах шаардлага		
2.1	Монгол Улсад бүртгэлтэй, стандартын шаардлага хангасан хүнсний нэмэлт, амтлагчууд хэрэглэдэг	10
2.2	Бэлэн бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтмол баталгаажуулдаг	5
Гурав.Өмнөх хяналт шалгалтын түүх		
3.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
3.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
3.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

- 15-30 оноо авсан бол их эрсдэлтэй
- 9-14 оноо авсан бол дунд эрсдэлтэй
- 8 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй



**08.5.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд
хамааруулах шалгуур, үзүүлэлт**

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Хүчин чадал		
1.1	10000-аас дээш өндөглөгчтэй, 80-аас дээш үндсэн мэгж гахайтай, саалийн 50-аас дээш үнээтэй, махны чиглэлийн 200-аас дээш мал, амьтан бүхий эрчимжсэн аж ахуй, 5-аас дээш бүл зөгий, загасны аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж	10
1.2	5000-10000 хүртэл өндөглөгчтэй, 30-80 хүртэл үндсэн мэгж гахайтай, саалийн 20-50 хүртэл үнээтэй, махны чиглэлийн 200 хүртэл мал, амьтан бүхий эрчимжсэн аж ахуй, 3-5 бүл зөгий, загас бүхий иргэн, аж ахуйн нэгж	7
1.3	5000 хүртэл өндөглөгчтэй, 30 хүртэл үндсэн мэгж гахайтай, саалийн 20 хүртэл үнээтэй, 3 хүртэл бүл зөгий бүхий иргэн, аж ахуйн нэгж	3
Хоёр. Мал, амьтны байрны нөхцөл		
2.1	Мал, амьтны зориулалтын байргүй, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй	10
2.2	Мал, амьтны зориулалтын хашаа, байртай боловч мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй	5
2.3	Мал, амьтны зориулалтын байртай мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан	1
Гурав. Мал, амьтны эрүүл мэндийн байдал		
3.1	Мал, амьтны гоц халдварт өвчин сүүлийн 1 жилд оношлогдсон	10
3.2	Мал, амьтны халдварт, паразиттах өвчин тухайн жилд оношлогдсон	5
3.3	Мал, амьтны гоц халдварт, халдварт, паразиттах өвчин сүүлийн 1 жилд оношлогдоогүй	1
Дөрөв. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хорио цээрийн байдал		
4.1	Гаднаас үндсэн сүрэгт нийлүүлсэн болон гадагшаа үржлийн зориулалтаар худалдаалсан мал, амьтан нь лабораторийн шинжилгээнд хамрагдаагүй тохиолдол давтан гарч байсан	10
4.2	Гаднаас үндсэн сүрэгт нийлүүлсэн болон гадагшаа үржлийн зориулалтаар худалдаалсан мал, амьтан нь лабораторийн шинжилгээгээр эрүүл гэдэг нь нотлогдоогүй тохиолдол гарч байсан	5
4.3	Гаднаас үндсэн сүрэгт нийлүүлсэн болон гадагшаа үржлийн зориулалтаар худалдаалсан мал, амьтан нь лабораторийн шинжилгээгээр эрүүл гэдэг нь нотлогдсон	1
Тав. Мал эмнэлгийн хяналт		
5.1	Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхэлдэг итгэмжлэгдсэн малын эмч, мал зүйчгүй, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлдэггүй	10
5.2	Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхэлдэг итгэмжлэгдсэн малын эмч, мал зүйчтэй, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлдэг	5
5.3	Мал эмнэлэг, үржлийн нэгжтэй, итгэмжлэгдсэн малын эмч, мал зүйчээр хангагдсан	1
Зургаа. Мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөл		



6.1	Мал сүрэгтээ аж ахуйн нэгжийн болон гэрээт мал эмнэлгийн нэгжээр малын эрүүл мэндийн үзлэг, мал, амьтны хашаа, байр, саравч, малын тоног хэрэгсэл, уст цэг зэрэгт халдваргүйтгэл болон халдварт өвчний үеийн хорио цээрийн арга хэмжээ авах ажил хийгддэггүй	10
6.2	Мал сүрэгтээ гэрээт мал эмнэлгийн нэгжээр малын эрүүл мэндийн үзлэг хийлгэх, мал, амьтны хашаа, байр, саравч, малын тоног хэрэгсэл, уст цэг зэрэгт халдваргүйтгэл хийх, халдварт өвчний үеийн хорио цээрийн арга хэмжээ авдаг	5
6.3	Мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийх, мал, амьтны байр, хашаа, саравч, тоног хэрэгсэл, уст цэгт халдваргүйтгэл хийх, хорио цээрийн арга хэмжээ авах ажлыг аж ахуйн нэгжийн болон гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр гүйцэтгэдэг	1
Долоо. Усан хангамж		
7.1	Фермер, аж ахуй нь төвлөрсөн, зөөврийн болон гар хийцийн худаггүй	10
7.2	Фермер, аж ахуй нь инженерийн хийц бүхий усан хангамжтай, хэсгийн шугам сүлжээгээр холбогдсон	5
7.3	Фермер, аж ахуй нь төвлөрсөн болон инженерийн хийц бүхий усан хангамжтай	1
Найм. Мал, амьтны тэжээлийн аюулгүй байдал		
8.1	Тэжээлийг хадгалах тусгай байр, агуулахгүй	10
8.2	Тэжээлийг хадгалах тусгай байр, агуулахтай боловч гарал үүсэл тодорхойгүй мал, амьтны тэжээл хэрэглэсэн тохиолдол гарч байсан	5
8.3	Тэжээлийг хадгалах тусгай байр, агуулахтай, гарал үүсэл тодорхой мал, амьтны тэжээл хэрэглэдэг	1
Ес. Хог хаягдлын менежмент		
9.1	Шаардлага хангасан хог хаягдлын цэггүй бөгөөд өвчнөөр болон зүй бусаар хорогдсон малын сэг, зэм, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн устгах цэг, байгууламжгүй	10
9.2	Шаардлага хангасан хог хаягдлын цэгтэй боловч өвчтэй, сэжигтэй мал, амьтны түүхий эд, бүтээгдэхүүн, сэг зэм устгалын цэггүй	5
9.3	Шаардлага хангасан хог хаягдлын цэгтэй, өвчтэй, сэжигтэй мал, амьтны түүхий эд, бүтээгдэхүүн, сэг зэм устгалын байгууламжтай	1
Арав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
10.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
10.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
10.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
<p>Үнэлгээ:</p> <p>50-100 оноо авсан бол их эрсдэлтэй</p> <p>30-49 оноо авсан бол дунд эрсдэлтэй</p> <p>29 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй</p>		

08.6. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Үйлчилгээний төрөл		
1.1	Ерөнхий мэргэжлийн тусламж үйлчилгээ, төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээ зэрэг олон төрлийн ажил үйлчилгээ эрхэлдэг	10
1.2	Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ эрхэлдэг	5
1.3	Тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээ эрхэлдэг	1
Хоёр. Үйлчилгээний хамрах хүрээ		
2.1	Нэг малын эмч 40,0 мянгаас дээш малд мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлдэг	10
2.2	Нэг малын эмч 25,0-40,0 мянга хүртэл толгой малд мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлдэг	5
2.3	Нэг малын эмч 25,0 мянга хүртэл толгой малд мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлдэг	1
Гурав. Мэргэжлийн боловсон хүчний хангалт		
3.1	Итгэмжлэлд хамрагдаагүй 1 малын эмчтэй	10
3.2	Итгэмжлэл бүхий 2-оос дээш малын их, бага эмчтэй, туслах болон техникийн ажилтантай	5
3.3	Итгэмжлэл бүхий 2-оос дээш малын их эмчтэй, туслах болон техникийн ажилтантай, орон тооны шинжлэгч эмчтэй	1
Дөрөв. Ажлын байр		
4.1	Байргүй	10
4.2	Байртай боловч эм бэлдмэл хадгалах агуулах, лаборатори, үзлэгийн өрөөний аль нэг нь байхгүй	5
4.3	Өөрийн болон түрээсийн байртай, эм, биобэлдмэл хадгалах зориулалтын агуулахтай, лабораторийн өрөөтэй (өрөө бүр тусдаа)	3
Тав. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж		
5.1	Мал эмнэлгийн лабораторийн болон мэс ажилбар, багаж хэрэгсэлгүй, мал угаалгын ванн буюу төхөөрөмжгүй	10
5.2	Мал эмнэлгийн лабораторийн болон мэс ажилбарын багаж хэрэгсэлтэй, мал угаалгын ванн буюу төхөөрөмжгүй	5
5.3	Мал эмнэлгийн лабораторийн болон мэс ажилбар, багаж хэрэгсэлтэй, мал угаалгын ванн буюу төхөөрөмжтэй	1
Зургаа. Нутаг дэвсгэр дэх өвчлөлийн байдал		
6.1	Хариуцсан нутаг дэвсгэрт нь сүүлийн 1 жилд халдварт, паразиттах өвчин аль аль нь оношлогдсон	10
6.2	Хариуцсан нутаг дэвсгэрт нь паразиттах өвчин гараагүй, халдварт өвчин оношлогдсон	5
6.3	Хариуцсан нутаг дэвсгэрт нь халдварт, паразиттах өвчин оношлогдоогүй	1
Долоо. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажуулалт		
7.1	Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийх лабораторигүй, мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ олгодоггүй	10



7.2	Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийх лабораторигүй, мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ олгодог	5
7.3	Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийх лабораторитой, мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ тогтмол олгодог	1
Найм. Халдварт, паразиттах өвчний судалгаа		
8.1	Хариуцсан нутаг дэвсгэрийн халдварт, паразиттах өвчний 5-аас доошгүй жилийн судалгаа, зураглалгүй	10
8.2	Хариуцсан нутаг дэвсгэрийн халдварт, паразиттах өвчний 5-аас доошгүй жилийн судалгаагүй, зураглалтай	5
8.3	Хариуцсан нутаг дэвсгэрийн халдварт, паразиттах өвчний 5-аас доошгүй жилийн судалгаа, зураглалтай	1
Ес. Мал эмнэлгийн үйлчилгээ, эм бэлдмэлийн тээвэрлэлт		
9.1	Мал эмнэлгийн нэгж нь дуудлагын тээврийн хэрэгсэл, эм вакцин хадгалах, зөөвөрлөх зориулалтын хөргүүргүй	10
9.2	Мал эмнэлгийн нэгж нь дуудлагын тээврийн хэрэгсэлтэй, эм вакцин хадгалах, зөөвөрлөх зориулалтын хөргүүргүй	5
9.3	Мал эмнэлгийн нэгж нь дуудлагын тээврийн хэрэгсэлтэй, эм вакцин хадгалах, зөөвөрлөх зориулалтын хөргүүртэй	1
Арав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
10.1	Өмнө хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
10.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
10.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

50-100 оноо авсан бол их эрсдэлтэй
30-49 оноо авсан бол дунд эрсдэлтэй
29 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

08.7. Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Мал үржлийн үйлчилгээний нэгжийн ажил, үйлчилгээ		
1.1	Мал үржлийн нэгжийн ажил, үйлчилгээ эрхлээгүй	10
1.2	Үржлийн цөм сүргийг шилэн сонгох, тохируулан сонгох, малд зохиомол болон гардан хээлтүүлэг явуулах ажлыг гүйцэтгэдэг боловч малын удам гарвал, үржил ашиг шимийн чанарыг тодорхойлж бүртгэлжүүлэх, баталгаажуулах, гойд ашиг шимт мал шалгаруулах, үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэдэггүй	5
1.3	Үржлийн цөм сүргийг шилэн сонгох, тохируулан сонгох, малд зохиомол болон гардан хээлтүүлэг явуулах, удам гарвал, үржил ашиг шимийн чанарыг тодорхойлж бүртгэлжүүлэх, баталгаажуулах, гойд ашиг шимт мал шалгаруулах, үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг мал үржлийн ажил үйлчилгээ эрхэлдэг	1
Хоёр. Хамрах хүрээ		
2.1	Нэг мал зүйчид оногдох малын тоо 50.0 мянгаас дээш толгой малд мал үржлийн ажил үйлчилгээ үзүүлдэг	10
2.2	Нэг мал зүйчид оногдох малын тоо 20.0-50.0 мянга хүртэл толгой малд мал үржлийн ажил үйлчилгээ үзүүлдэг	5
2.3	Нэг мал зүйчид оногдох малын тоо 20.0 мянгаас доош толгой малд мал үржлийн ажил үйлчилгээ үзүүлдэг	1
Гурав. Үйл ажиллагаа		
3.1	Үржлийн малын бүртгэлжүүлэлтгүй, малын ашиг шимийн үзүүлэлтийн мэдээллийн сангүй	10
3.2	Үржлийн малын бүртгэлжүүлэлттэй, малын ашиг шимийн үзүүлэлтийн мэдээллийн сангүй	5
3.3	Үржлийн малын бүртгэлжүүлэлттэй, малын ашиг шимийн үзүүлэлтийн мэдээллийн сантай	1
Дөрөв. Мэргэжлийн боловсон хүчний хангалт		
4.1	Мал үржлийн үйлчилгээний нэгж нь мал зүйчтэй, мэргэшсэн зохиомол хээлтүүлгийн технологич болон шаардлагатай үед ажиллах орон тооны бус ажилчингүй	10
4.2	Мал үржлийн үйлчилгээний нэгж нь мал зүйчтэй, мэргэшсэн зохиомол хээлтүүлгийн технологичтой, шаардлагатай үед ажиллах орон тооны бус ажилчингүй	5
4.3	Мал үржлийн үйлчилгээний нэгж нь мал зүйч, мэргэшсэн зохиомол хээлтүүлгийн технологич болон шаардлагатай үед ажиллах орон тооны бус ажилчинтай	1
Тав. Ажлын байр, тоног төхөөрөмж		
5.1	Мал үржлийн үйлчилгээний нэгж нь зориулалтын байр, албан ажлын өрөө болон зохиомол хээлтүүлгийн байргүй	10



5.2	Мал үржлийн үйлчилгээний нэгж нь зориулалтын байртай боловч үр хөврөл, үр болон бэлдмэл хадгалах, тээвэрлэх зориулалтын тоног төхөөрөмж, зохиомол хээлтүүлгийн байр, үзлэг ангилалтын хашаа, мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарц, чанарыг тодорхойлох багаж хэрэгсэл, үйлчилгээний уналга, тээврийн хэрэгсэлгүй	5
5.3	Мал үржлийн үйлчилгээний нэгж нь зориулалтын байр, албан ажлын өрөө, үр хөврөл, үр болон бэлдмэл хадгалах, тээвэрлэх зориулалтын тоног төхөөрөмж, зохиомол хээлтүүлгийн байр, үзлэг ангилалтын хашаа, мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарц, чанарыг тодорхойлох багаж хэрэгсэл, үйлчилгээний уналга, тээврийн хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын иж бүрэн хувцас, хэрэгсэл, үржлийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчтэй	3
Зургаа. Лабораторийн үзлэг, шинжилгээ		
6.1	Үржлийн малд лабораторийн үзлэг, шинжилгээ хийдэггүй	10
6.2	Үржлийн малд лабораторийн үзлэг, шинжилгээг бүрэн гүйцэтгэдэггүй	5
6.3	Үржлийн малын амьдын жин, нядлагын гарц, сүүний гарц, тослог, арьс ширний чанар, тэжээлийн шинж чанар, ноос, ноолуурын гарц, чанар, хээлтүүлэгчийн үрийн чанар тодорхойлох үзлэг шинжилгээ хийдэг	1
Долоо. Үйлчилгээний нэгжид байх багаж, хэрэгсэл		
7.1	Мал үржлийн үйлчилгээний нэгжид байх шаардлагатай (зохиомол хээлтүүлгийн) багаж хэрэгсэлгүй	10
7.2	Мал үржлийн үйлчилгээний нэгжийн багаж шаардлагатай (зохиомол хээлтүүлгийн) багаж хэрэгсэл бүрэн бус	5
7.3	Хөргөгч, микроскопын иж бүрдэл, тариур, хуруун шил, дусаагуур, хатаах шүүгээ, ус нэрэгч, зохиомол хээлтүүлгийн иж бүрдэл (бод, бог), ээмэг, ээмэглэгч бахь, им тавигч, шивүүр дугаар тавигчийн иж бүрдэл, мал жинлэх пүү, палкметр, циркуль, лентметр, малын үр хадгалах дьюарын сав, сүүний чанар тодорхойлогч, компьютерын иж бүрдэлтэй	1
Найм. Өмнөх хяналт шалгалтын түүх		
8.1	Өмнө хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
8.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
8.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
<p>Үнэлгээ:</p> <p>40-80 оноо авсан бол их эрсдэлтэй</p> <p>24-39 оноо авсан бол дунд эрсдэлтэй</p> <p>23 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй</p>		

**08.8.Малын эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн худалдаа,
үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд
хамааруулах шалгуур, үзүүлэлт**

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Үйл ажиллагааны төрөл		
1.1	Эм найруулдаг эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага	10
1.2	Эм найруулдаггүй эмийн сан	5
Хоёр. Ажлын байрны нөхцөл		
2.1	Батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, технологийн урсгалыг зөв зохион байгуулаагүй, шаардлагатай өрөө тасалгаагаар бүрэн хангагдаагүй	10
2.2	Батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй боловч технологийн урсгалыг зөв зохион байгуулж шаардлагатай өрөө тасалгаагаар бүрэн хангагдсан	5
2.3	Батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, технологийн урсгалыг зөв зохион байгуулж шаардлагатай өрөө тасалгаагаар бүрэн хангагдсан	1
Гурав. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн үйлчилгээ		
3.1	Үйлчилдэг	10
3.2	Үйлчилдэггүй	1
Дөрөв. Стандартад заагдсан эм зүйн мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал		
4.1	Хангагдаагүй	10
4.2	Хангагдсан	1
Тав. Усан хангамж		
5.1	Төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй	5
5.2	Хэсгийн холболттой	3
5.3	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Зургаа. Дулаан хангамж		
6.1	Төвлөрсөн болон хэсгийн халаалтын системд холбогдоогүй	5
6.2	Хэсгийн халаалттай	3
6.3	Төвлөрсөн халаалтын системд холбогдсон	1
Долоо. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн тээвэрлэлтийн нөхцөл		
7.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
7.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч, температурын шаардлага хангахуйц тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй	5
7.3	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй	1
Найм. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн хадгалалтын нөхцөл		
8.1	Зориулалтын агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	10
8.2	Агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	5
8.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан агуулах, тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн хангагдсан	1



Ес. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээлэл		
9.1	Хууль тогтоомжийг ноцтой зөрчсөний улмаас их хэмжээний торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил давтан гардаг, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож байсан	10
9.2	Хууль тогтоомжийг биелүүлж ажиллаагүйн улмаас торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг дутуу биелүүлдэг	5
9.3	Хууль тогтоомж болон улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

45-90 оноо авсан бол их эрсдэлтэй

28-44 оноо авсан бол дунд эрсдэлтэй

27-оос доош оноо авсан бол бага эрсдэлтэй

08.9.Малын эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Үйлдвэрлэлийн технологийн онцлог		
1.1	Тарилгын эм, антибиотик, биобэлдмэл үйлдвэрлэдэг	10
1.2	1.1-д зааснаас бусад нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэдэг	1
Хоёр. Үйлдвэрийн хүчин чадал		
2.1	10-аас дээш нэр төрлийн эм бэлдмэл, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэдэг	10
2.2	5-10 нэр төрлийн эм бэлдмэл, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэдэг	5
2.3	5 хүртэл нэр төрлийн эм бэлдмэл, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэдэг	1
Гурав. Үйлдвэрийн барилга, байгууламж		
3.1	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй барилга байгууламж, тоног төхөөрөмж хэрэгсэлтэй	10
3.2	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар зөв зохион байгуулсан	5
3.3	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламжтай, үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар зөв зохион байгуулж, орц гарцыг шаардлагын дагуу гаргасан	1
Дөрөв. Үйлдвэрийн агааржуулалт		
4.1	Шаардлага хангасан агааржуулалтын системгүй, хянах төхөөрөмжгүй	10



4.2	Агааржуулалтын системтэй боловч, хяналтын төхөөрөмжгүй	5
4.3	Хяналтын төхөөрөмж бүхий шаардлага хангасан агааржуулалтын системтэй	1
Тав. Усан хангамж		
5.1	Төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй	10
5.2	Хэсгийн холболттой	5
5.3	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Зургаа. Тээвэрлэлтийн нөхцөл		
6.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
6.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч, температурын шаардлага хангахуйц тоноггосон тээврийн хэрэгсэлтэй	5
6.3	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй	1
Долоо. Үйлдвэрийн дотоод хяналтын лаборатори		
7.1	Дотоод хяналтын лабораторигүй	10
7.2	Дотоод хяналтын лабораторитой боловч итгэмжлэгдээгүй	5
7.3	Итгэмжлэгдсэн лабораторитой	1
Найм. Эм, бүтээгдэхүүний чанар		
8.1	Сүүлийн 2 хүртэлх жилийн хугацаанд хөндлөнгийн хяналтаар авсан дээж лабораторийн шинжилгээгээр шаардлага хангаагүй дүнтэй гарсан	10
8.2	Сүүлийн 2 хүртэлх жилийн хугацаанд хөндлөнгийн хяналтаар авсан дээж лабораторийн шинжилгээгээр шаардлага хангасан дүнтэй гарсан	1
Ес. Эмийн гомдол мэдээлэл, гаж нөлөө, буцаалт, татан авалт гарсан байдал		
9.1	Сүүлийн 3 хүртэлх жилд үйлдвэрлэсэн эм, тэжээлийн нэмэлттэй холбоотой санал, гомдол, мэдээлэл ирсэн, эмийн гаж нөлөө, буцаалт, татан авалт хийгдэж байсан	10
9.2	Сүүлийн 3-5 хүртэлх жилд үйлдвэрлэсэн эм, тэжээлийн нэмэлттэй холбоотой санал, гомдол, мэдээлэл ирээгүй, эмийн гаж нөлөө, буцаалт, татан авалт хийгдэж байсан	5
9.3	Сүүлийн 5 хүртэлх жилд үйлдвэрлэсэн эм, тэжээлийн нэмэлттэй холбоотой санал, гомдол, мэдээлэл ирээгүй, эмийн гаж нөлөө, буцаалт, татан авалт хийгдээгүй	1
Арав. Үйлдвэрлэлийн зохистой дадал		
10.1	Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлээгүй	10
10.2	Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлсэн	1
Арван нэг. Түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
11.1	Зориулалтын агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	10
11.2	Агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	5
11.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан агуулах, тоног төхөөрөмж хэрэгсэлээр бүрэн хангагдсан	1
Арван хоёр. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээлэл		



12.1	Хууль тогтоомж, шаардлагыг зөрчсөний улмаас арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил давтагдан гардаг, зөрчлийг бууруулах арга хэмжээ авдаггүй	10
12.2	Хууль тогтоомж, шаардлагыг биелүүлж ажиллаагүйн улмаас арга хэмжээ авагдаж байсан, зөрчлийг бууруулах арга хэмжээ авч ажилладаг, хууль тогтоомж, стандартын шаардлагыг бүрэн биелүүлээгүй	5
12.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

60-120 оноо авсан бол их эрсдэлтэй

40-59 оноо авсан бол дунд эрсдэлтэй

39-өөс бага оноо авсан бол бага эрсдэлтэй

08.10.Тариалан эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Таримлын төрөл		
1.1	Түргэн гэмтэж мууддаг хүнсний ногоо, жимс жимсгэнэ (навчит ногоо, цэцэгт байцаа, лооль, хэмх, мөөг, банана, усан үзэм, үхрийн нүд, чацаргана гэх мэт)	10
1.2	Төмс, хүнсний ногоо (байцаа, манжин, лууван, сонгино, саримс гэх мэт)	5
1.3	Үр тарианы таримал (буудай, арвай, хөх тариа, бог будаа гэх мэт)	3
Хоёр. Ургацын хэмжээ (ил талбайн тариалалт, хүлэмж)		
2.1	300 тонноос дээш	10
2.2	50-300 тонн хүртэлх	5
2.3	50 тонн хүртэлх	1
Гурав. Түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал		
3.1	Гадаад хорио цээртэй ургамлын өвчин, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч илэрч байсан, химийн бодисын үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдол бүртгэгдсэн	10
3.2	Дотоод хорио цээртэй ургамлын өвчин, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч илэрч байсан	5
3.3	Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалтай холбоотой өргөдөл, гомдол сүүлийн 1 жилд гарч байсан	3
3.4	Гадаад, дотоод хорио цээртэй ургамлын өвчин, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч илрээгүй, химийн бодисын үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй	1
2.3	Норм, дүрмийн шаардлага хангасан эдэлбэр газартай, биеийн тамир, тоглоом, туршилт, амралтын талбай, ногоон байгууламжтай	1
Гурав. Хүчин чадал		
3.1	Барилгын төлөвлөлтийн хүчин чадлаас хэтэрсэн	10
3.2	Барилгын төлөвлөлтийн хүчин чадлаас хэтрээгүй	1
Дөрөв. Анги танхим, өрөө тасалгааны агааржуулалт		
4.1	Агаарын солилцоо хангалтгүй, агааржуулалтын төхөөрөмжгүй	10
4.2	Зориулалтын бус агааржуулалтын төхөөрөмжтэй	5
4.3	Агаарын солилцоо хангалттай	1
Тав. Анги танхим, өрөө тасалгааны гэрэлтүүлэг		
5.1	Зохиомол ба байгалийн гэрэлтүүлэг хангалтгүй	10
5.2	Зохиомол ба байгалийн гэрэлтүүлэг хангалттай	1
Зургаа. Усан хангамж, бохир ус зайлуулалт		
6.1	Зөөврийн	10
6.2	Хэсгийн	5
6.3	Төвлөрсөн	1
Долоо. Дулаан хангамж		
7.1	Хэсгийн	10
7.2	Төвлөрсөн	1
Найм. Ариун цэврийн тоног төхөөрөмж		



8.1	Ариун цэврийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй	10
8.2	Ариун цэврийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй боловч бүрэн ажиллагаагүй	5
8.3	Ариун цэврийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй, бүрэн ажиллагаатай	1
Ес. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ		
9.1	Зориулалтын бус байртай, өрөө тасалгаа хүрэлцээгүй	10
9.2	Зориулалтын байртай, технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар зөв зохион байгуулсан, өрөө тасалгаа хүрэлцээтэй	1
Арав. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
10.1	Хүнсний бүтээгдэхүүний агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж, хэрэгсэлгүй	10
10.2	Хүнсний бүтээгдэхүүний агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдаагүй	5
10.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан агуулах, тоног төхөөрөмж, хэрэгслээр бүрэн хангагдсан	1
Арав нэг. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн нөхцөл		
11.1	Зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг	10
11.2	Зориулалтын бус боловч хүнсний бүтээгдэхүүнийг дам бохирдол үүсэхээс сэргийлсэн нөхцөлд тээвэрлэхээр тоноггосон тээврийн хэрэгсэл ашигладаг	5
11.3	Зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг	1
Арван хоёр. Хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдвар гарсан байдал		
12.1	Хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдвар сүүлийн 3 жилд гарсан/тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой	10
12.2	Тухайн байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эрүүл ахуйн нөхцөл, шаардлагатай холбоотой санал, гомдол сүүлийн 2 жилд гарч байсан	5
12.3	Хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдвар гараагүй/тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой	1
Арван гурав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
13.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
13.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
13.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
<p>Үнэлгээ:</p> <p>65-130 оноо авсан бол их эрсдэлтэй</p> <p>39-64 оноо авсан бол дунд эрсдэлтэй</p> <p>38 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй</p>		

10.7.Ахуйн хог хаягдлыг цуглуулж, устгах үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт (эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт)

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх зөвшөөрөл		
1.1	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүй	10
1.2	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан, зөвшөөрөлтэй	1
Хоёр. Энгийн хог хаягдал цуглуулах хогийн савны шаардлага		
2.1	Хогийн сав хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцээгүй	10
2.2	Хогийн сав хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн	1
Гурав. Хогийн савны хүрэлцээ хангамж		
3.1	Орон сууц, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын болон нийтийн эдэлбэр газарт байршуулсан хогийн сав үүсэж буй хог хаягдлын хэмжээнээс бага багтаамжтай, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ил задгай хог үүссэн	10
3.2	Орон сууц, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын болон нийтийн эдэлбэр газарт байршуулсан хогийн сав үүсэж буй хог хаягдлын хэмжээнд тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн	1
Дөрөв. Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тээврийн хэрэгслийн хангалт		
4.1	Хог хаягдлыг ангилан ялгадаггүй, төвлөрсөн цэгт зөөвөрлөх тээврийн хэрэгсэл хангалтгүй	10
4.2	Хог хаягдлыг ангилан ялгадаг, төвлөрсөн цэгт зөөвөрлөх тээврийн хэрэгсэл хангалтгүй	8
4.3	Хог хаягдлыг ангилан ялгаж, төвлөрсөн цэгт зөөвөрлөх тээврийн хэрэгсэл хангалттай	1
Тав. Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарь		
5.1	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулж ажилладаггүй	10
5.2	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулдаг боловч хуваарийн дагуу ажилладаггүй	8
5.3	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулж, хуваарийн дагуу ажилладаг	1
Зургаа. Хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах байгууламж		
6.1	Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах байгууламжгүй	10
6.2	Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах байгууламжтай боловч хуульд заасан нийтлэг шаардлагыг хангаагүй	8



6.3	Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах байгууламж хуульд заасан нийтлэг шаардлагыг хангасан	1
Долоо. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн бүтэц, үйл ажиллагаа		
7.1	Хог хаягдлын төвлөрсөн цэг эрүүл ахуйн шаардлага хангахгүй (хашаагүй, хэмжих хэрэгсэлгүй, шүүрлийн ус, хорт хий зайлуулах тоног төхөөрөмжгүй, ус, хөрс, агаарын бохирдлыг хянадаггүй)	10
7.2	Хог хаягдлын төвлөрсөн цэг хашаатай, хэмжих хэрэгсэлтэй, харуул хамгаалалттай боловч бусад хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй	8
7.3	Гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгтэй	5
7.4	Нэг, хоёрдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгтэй	1
Найм. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн машин, техникийн хангамж		
8.1	Хог хаягдлыг нягтруулж булшлах машин, техник, хэрэгсэлгүй	10
8.2	Хог хаягдлыг нягтруулж булшлах машин, техник, хэрэгсэл хүрэлцээгүй	8
8.3	Хог хаягдлыг нягтруулж булшлах машин, техник, хэрэгсэл хангалттай	1
Ес. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ		
9.1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй	10
9.2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн	1
Арав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		
10.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй	10
10.2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй боловч биелэлтийг ханган ажилладаггүй	8
10.3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилладаг	1
Арван нэг. Өмнөх хяналт шалгалтын түүх		
11.1	Өмнө хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
11.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	8
11.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
<p>Үнэлгээ:</p> <p>55-110 оноо авсан бол их эрсдэлтэй</p> <p>33-54 оноо авсан бол дунд эрсдэлтэй</p> <p>32 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй</p>		

10.8. Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт (эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт)

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа		
1.1	Механик цэвэрлэгээ хийж, байгальд нийлүүлдэг	10
1.2	Механик, биологийн цэвэрлэгээ хийж, байгальд нийлүүлдэг	8
1.3	Механик, биологийн цэвэрлэгээ хийж, халдваргүйжүүлсний дараа байгальд нийлүүлдэг	1
Хоёр. Бохир усны төрөл		
2.1	Үйлдвэр, эмнэлгийн бохир усыг урьдчилан цэвэрлэхгүйгээр төвлөрсөн шугамд нийлүүлдэг	10
2.2	Үйлдвэрийн бохир усыг урьдчилан цэвэрлэхгүйгээр төвлөрсөн шугамд нийлүүлдэг	8
2.3	Эмнэлгийн бохир усыг урьдчилан цэвэрлэхгүйгээр төвлөрсөн шугамд нийлүүлдэг	5
2.4	Үйлдвэр, эмнэлгийн бохир усыг урьдчилан цэвэрлэж, стандартын шаардлага хангасан бохир усыг нийлүүлдэг	1
Гурав. Лагийн менежмент		
3.1	Лагийн талбайгүй	10
3.2	Лагийн талбайтай, лаганд боловсруулалт (усгүйжүүлэх, преслэх) хийхгүй хаядаг	8
3.3	Лагийн талбайтай, лаганд боловсруулалт хийж хаядаг	1
Дөрөв. Лагийн халдваргүйжүүлэлт		
4.1	Лаганд халдваргүйжүүлэлт хийдэггүй	10
4.2	Лаганд халдваргүйжүүлэлт хийдэг	1
Тав. Цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бүсийн дэглэм		
5.1	Цэвэрлэх байгууламжийн хүчин чадлаас хамаарч эрүүл ахуйн хамгаалалтын бүс стандартад заасан хэмжээгээр тогтоогоогүй, бүсийн дэглэм зөрчигдсөн	10
5.2	Цэвэрлэх байгууламжийн хүчин чадлаас хамаарч эрүүл ахуйн хамгаалалтын бүс стандартад заасан хэмжээгээр тогтоосон боловч бүсийн дэглэм зөрчигдсөн	8
5.3	Цэвэрлэх байгууламжийн хүчин чадлаас хамаарч эрүүл ахуйн хамгаалалтын бүс стандартад заасан хэмжээгээр тогтоож, бүсийн дэглэмийн шаардлага хангасан	1
Зургаа. Цэвэрлэх байгууламжийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ		
6.1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй	10
6.2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн	1
Долоо. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		
7.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй	10
7.2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй боловч биелэлтийг ханган ажилладаггүй	8
7.3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилладаг	1
Найм. Дотоод хяналт		
8.1	Цэвэрлэсэн бохир усанд химийн бохирдлын үзүүлэлтээр болон нян судлалын шинжилгээ хийх дотоод хяналтын лабораторитой	10



8.2	Цэвэрлэсэн бохир усанд химийн бохирдлын үзүүлэлтээр шинжилгээ хийх дотоодын хяналтын лабораторитой	5
8.3	Цэвэрлэсэн бохир усанд химийн бохирдлын үзүүлэлтээр болон нян судлалын шинжилгээ хийх лабораторитой	1
Ес. Өмнөх хяналт шалгалтын түүх		
9.1	Өмнө хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
9.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
9.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

45-90 оноо авсан бол их эрсдэлтэй
27-44 оноо авсан бол дунд эрсдэлтэй
26 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

10.9. Хот, суурины ус хангагч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт (эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт)

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Хүн амын үндны ус хангамжийн эх үүсвэр		
1.1	Урсгал усыг ус хангамжийн эх үүсвэрт ашигладаг	10
1.2	Урсгал уснаас шууд тэжээгдэх худгийн ус ашигладаг	8
1.3	Хөрсний ус хялбар нэвтрэх уст үеэс усыг ус хангамжийн эх үүсвэрт ашигладаг	6
1.4	Хөрсний уснаас хамгаалагдсан уст үеийн усыг ус хангамжийн эх үүсвэрт ашигладаг	1
Хоёр. Хамгаалалтын бүс тогтоосон байдал		
2.1	Эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс тогтоогоогүй	10
2.2	Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, бүсийн хэмжээгээр хашаажуулсан, энгийн хамгаалалтын бүс тогтоогоогүй	8
2.3	Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож бүсийн хэмжээгээр хашаажуулсан, энгийн хамгаалалтын бүс тогтоож тэмдэгжүүлсэн	1
Гурав. Хамгаалалтын бүсийн дэглэм		
3.1	Хамгаалалтын бүсэд газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, цацраг идэвхт бодис хадгалдаг, хөрсөнд төрөл бүрийн бордоо хэрэглэдэг, химийн бодис ашиглан хөнөөлт шавж, мэрэгчийг устгадаг	10
	Хамгаалалтын бүсэд үйлдвэрийн болон ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж, бохирын цооног, хатуу хог хаягдлын цэг байрладаг Хамгаалалтын бүсийн заагийг тогтоож, хаалт хамгаалалт хийгээгүй мал, амьтан орох боломжтой	

3.2	Хамгаалалтын бүсэд орон сууц, бусад үйлчилгээний барилга, байгууламж байрладаг	9
3.3	Хамгаалалтын бүсийн дэглэмийн зөрчилгүй	1
Дөрөв. Харуул хамгаалалт		
4.1	Улсын зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэр тусгай хамгаалалтгүй, аймаг, сумын зэрэглэлтэй газруудын ус хангамжийн эх үүсвэр харуул хамгаалалтгүй	10
4.2	Улсын зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэр энгийн харуул хамгаалалттай	8
4.3	Улсын зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэр тусгай хамгаалалттай, аймаг, сумын зэрэглэлтэй газруудын ус хангамжийн эх үүсвэр энгийн харуул хамгаалалттай	1
Тав. Ундны усны эх үүсвэрийн усан сан		
5.1	Ус хадгалах усан сангийн хийцийн материал тодорхой бус, эрүүл ахуйн шаардлага хангахгүй	10
5.2	Ус хадгалах усан сангийн хийцийн материал усны чанар, аюулгүй байдалд нөлөө үзүүлэхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан	1
Зургаа. Гамшгийн үеийн удирдлагын горим		
6.1	Усны эх үүсвэр эрсдэлд өртсөн тохиолдолд усны найдвартай нөөц, эх үүсвэрийг ашиглах боломж бүрдээгүй	10
6.2	Усны эх үүсвэр эрсдэлд өртсөн тохиолдолд усны найдвартай нөөц, эх үүсвэртэй	1
Долоо. Усны халдваргүйтгэл		
7.1	Усны халдваргүйтгэл хийдэггүй	10
7.2	Усны халдваргүйтгэл хийдэг боловч хяналт тогтмолжоогүй, үлдэгдэл хлорын хэмжээг тогтмол хянадаггүй	8
7.3	Усны халдваргүйтгэл хийдэг, үлдэгдэл хлорын хэмжээг тогтмол тодорхойлдог	1
Найм. Ус түгээх цэг		
8.1	Ус түгээх цэг нь төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнд холбогдоогүй	10
8.2	Ус түгээх цэг нь төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон	5
Ес. Ундны усны хяналт, шинжилгээ		
9.1	Дотоод хяналтын лабораторигүй, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаггүй	10
9.2	Дотоод хяналтын лабораторигүй, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаг	8
9.3	Бичил амь судлалын аюулгүйн үзүүлэлтээр дотоод хяналтад тогтмол, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаг	3
9.4	Хими, бичил амь судлалын аюулгүйн үзүүлэлтээр дотоод хяналтад тогтмол, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаг	1
Арав. Ундны усны чанар, аюулгүй байдал		
10.1	Ундны ус нь хими, нян судлал, хүнд металлын шинжилгээгээр стандартын шаардлага хангадаггүй	10



10.2	Ундны ус нь хими, нян судлал, хүнд металлын шинжилгээгээр стандартын шаардлага хангадаг	1
Арван нэг. Өмнөх хяналт шалгалтын түүх		
11.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
11.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
11.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

55-110 оноо авсан бол их эрсдэлтэй

33-54 оноо авсан бол дунд эрсдэлтэй

32 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

10.10. Ахуйн үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөөр эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Ажлын байрны эрүүл ахуйн шаардлага		
1.1	Ажлын байр нь зориулалтын бус, засвар өөрчлөлт хийгээгүй, шаардлагатай өрөө тасалгаа хангалтгүй	10
1.2	Ажлын байр нь зориулалтын бус, засвар өөрчлөлт хийсэн, өрөө тасалгаа байгаа боловч шаардлага хангаагүй	5
1.3	Тухайн үйлчилгээний чиглэлээр зураг төслийн дагуу баригдсан өөрийн байранд үйл ажиллагаа явуулдаг	1
Хоёр. Хүчин чадал		
2.1	Барилгын төлөвлөлтийн хүчин чадлаас хэтэрсэн	10
2.2	Барилгын төлөвлөлтийн хүчин чадлаас хэтрээгүй	1
Гурав. Ажлын байрны агааржуулалт		
3.1	Агаарын солилцоо хангалтгүй явагддаг, агааржуулалтын төхөөрөмжгүй	10
3.2	Зориулалтын бус агааржуулалтын төхөөрөмжтэй	5
3.3	Агаарын солилцоо хангалттай	1
Дөрөв. Ажлын байрны гэрэлтүүлэг		
4.1	Зохиомол ба байгалийн гэрэлтүүлэг хангалтгүй	10
4.2	Зохиомол ба байгалийн гэрэлтүүлэг хангалттай	1
Тав. Усан хангамж, бохир ус зайлуулалт		
5.1	Зөөврийн	10
5.2	Хэсгийн	5
5.3	Төвлөрсөн	1
Зургаа. Ариун цэврийн тоног төхөөрөмж		
6.1	Ариун цэврийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй	10
6.2	Ариун цэврийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй боловч бүрэн ажиллагаагүй	5



6.3	Ариун цэврийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй, бүрэн ажиллагаатай	1
Долоо. Цэвэрлэгээ, халдваргүйтгэл		
7.1	Цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийгддэггүй, шавж, мэрэгч амьтан үржих, үүрлэх нөхцөл бүрдсэн	10
7.2	Цэвэрлэгээ, халдваргүйтгэл тогтмол хийгддэггүй, шавж, мэрэгч амьтан үржих, үүрлэхээс сэргийлэх арга хэмжээ авдаг боловч дотоод хяналт тавьдаггүй	5
7.3	Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гэрээгээр халдваргүйтгэл тогтмол хийлгэдэг, эсвэл тухайн байгууллага зааврын дагуу устгалыг хийдэг, шавж, мэрэгч амьтан үржиж, үүрлэхээс бүрэн хамгаалсан	1
Найм.Гоо сайхан, үсчний үйлчилгээний багаж хэрэгслийн угаалга, халдваргүйтгэл, ариутгалын үйл ажиллагаа		
8.1	Үйлчилгээнд хэрэглэж буй багаж хэрэгслийн эрсдэлийн түвшингээс хамааруулан угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагаа хийгддэггүй	10
8.2	Багаж хэрэгслийг угааж цэвэрлэдэг боловч халдваргүйжүүлэлт хийдэггүй	5
8.3	Багаж хэрэгслийн эрсдэлийн түвшингээс хамааруулан угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагааг бүрэн хийдэг	1
Ес.Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт		
9.1	Халдварт өвчин дэгдэлт хэлбэрээр гарсан, эсвэл халдварт өвчин гарахад нөлөөлж болзошгүй хүчин зүйлийн үнэлгээг хийгээгүй, холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй	10
9.2	Халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн, эсвэл халдварт өвчин гарахад нөлөөлж болзошгүй хүчин зүйлийн үнэлгээг хийсэн боловч холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй	5
9.3	Халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй болон халдварт өвчин гарахад нөлөөлж болзошгүй хүчин зүйлийн үнэлгээг хийдэг, холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг	1
Арав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
10.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
10.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
10.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

50-100 оноо авсан бол их эрсдэлтэй

30-49 оноо авсан бол дунд эрсдэлтэй

29 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй



10.11. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч этгээдийг эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөөр эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Хүнсний бүтээгдэхүүний төрөл		
1.1	Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, (мах, сүү, загас, өндөг, нөөшилсөн загас), хагас боловсруулсан бүтээгдэхүүн (мах махан бүтээгдэхүүн), мал, амьтны болон ургамал, ургамлын гаралтай дахин боловсруулахгүйгээр шууд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн (төрөл бүрийн хиам, зайдас, нухаш, утсан загас, мах, дулааны боловсруулалт хийгээгүй жимс, ногооны шүүс гэх мэт), өтгөрүүлсэн, хуурай сүү, төрөл бүрийн зайрмаг, өндөр хэмд болгоогүй кремтэй гурилан бүтээгдэхүүн (бялуу, жигнэмэг, нарийн боов), тусгай зориулалтын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	10
1.2	Төрөл бүрийн чихэр, чихрэн бүтээгдэхүүн, шоколад, зефир, үрэл, зөгийн бал, дулааны боловсруулалт хийсэн ургамал, ургамлын гаралтай нөөшилсөн (жимсний чанамал, компот, жимсний шүүс, даршилсан хүнсний ногоо) болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, савласан цэвэр ус, рашаан	5
1.3	Үр тариа тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн (талх, төрөл бүрийн шанз, кремгүй бусад гурилан бүтээгдэхүүн, архи, спирт, дарс, шар айраг, квас, хийжүүлсэн ундаа, төрөл бүрийн ундаа, цай, бусад хүнсний бүтээгдэхүүн)	1
Хоёр. Онцгой бүлэгт зориулсан хүнс		
2.1	Нялх, балчир хүүхдийн хүнс, хоолны онцгой дэглэмтэй хүмүүс, эмнэлэг, сувилалд хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүст зориулсан хүнс	10
2.2	Бусад	1
Гурав. Үйлдвэрлэлийн хүчин чадал		
3.1	Хоногт 3.1 тонноос илүү бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	10
3.2	Хоногт 0.5–3 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	5
3.2	Хоногт 0.5 тонноос бага хэмжээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	1
Дөрөв. Үйлдвэрлэлийн барилга байгууламж		
4.1	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, эрх бүхий байгууллага барилгыг ашиглалтад хүлээн аваагүй, стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй зориулалтын бус барилга байгууламжтай	10
4.2	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, технологи, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламжтай	5
4.3	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, технологи стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламжтай	1
Тав. Цэвэр усан хангамж, бохир ус зайлуулах татуургын систем		
5.1	Үйлдвэр, цехийн барилга байгууламж нь инженерийн төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй	10
5.2	Үйлдвэр, цехийн шугам сүлжээ нь хэсгийн холболттой	5
5.3	Үйлдвэр, цехийн барилга байгууламж нь инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Зургаа. Үйлдвэрлэлийн шугам, тоног төхөөрөмж		



6.1	Хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь ажилчдаас хамаарсан гар ажиллагаа ихтэй	10
6.2	Үйлдвэрлэлийн шугам, тоног төхөөрөмж нь механикжсан хагас автоматажсан бүтээгдэхүүний савлалт гар ажиллагаатай	5
6.3	Бүрэн автомат шугамтай	1
Долоо. Түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
7.1	Хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	10
7.2	Хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж, хэрэгсэлгүй, эсхүл агуулахгүй боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгслээр хангагдсан	5
7.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан төрөлжсөн агуулах, тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн хангагдсан	1
Найм. Тээвэрлэлтийн нөхцөл		
8.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бүс	10
8.2	Хүнсний бүтээгдэхүүнийг дам бохирдол үүсэхээс сэргийлсэн нөхцөлд тээвэрлэхээр тоноглогсон тээврийн хэрэгсэл ашигладаг, эсвэл гэрээт байгууллагаар тээвэрлүүлдэг	5
8.3	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй	1
Ес. Хүнсний үйлдвэрлэлийн хүний нөөц		
9.1	Мэргэжлийн мэргэшсэн ажилтнаар хангагдаагүй	10
9.2	Мэргэжлийн мэргэшсэн ажилтан ажиллагсадгүй боловч гэрээгээр ажиллуулдаг, сургалтад хамрагдсан	5
9.3	Мэргэжлийн мэргэшсэн хүний нөөцтэй	1
Арав. Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байдал		
10.1	Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, хэрэгжүүлдэггүй	10
10.2	Дотоод хяналтын алба/ажилтантай боловч, журам мөрддөггүй, хэрэгжүүлдэггүй	5
10.3	Дотоод хяналтыг хэрэгжүүлдэг тогтмолжсон	1
Арван нэг. Өмнөх хяналт шалгалтын түүх		
11.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
11.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
11.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
Арван хоёр. Хүнсний гаралтай хордлого, хордлогот халдвар гарсан байдал		
12.1	Сүүлийн 3 жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс нь хүнсний гаралтай хордлого, хордлогот халдвар гарсан	10
12.2	Сүүлийн 1 жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй холбоотой гомдол гарч байсан	5
12.3	Сүүлийн 3 жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс нь хүнсний гаралтай хордлого, хордлогот халдвар, гомдол гарч байгаагүй	1

Үнэлгээ:

60–120 оноо авсан бол их эрсдэлтэй

36–59 оноо авсан бол дунд эрсдэлтэй

35 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

10.12.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөөр эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Хоол үйлдвэрлэлийн хүчин чадал		
1.1	501-ээс дээш порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	10
1.2	500 хүртэлх порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	5
Хоёр. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт		
2.1	Эмнэлэг, сувилал, ахмад настны болон хүүхдийн асрамжийн байгууллага, хүүхдийн зуслан, цэцэрлэг, сургууль, цэргийн анги, хорих газрын хоолны газар, төмөр зам, онгоцоор зорчигчдод зориулсан катерингийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй бол	10
2.2	Бусад хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар	5
Гурав. Ажлын байрны нөхцөл		
3.1	Батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, зориулалтын бус байранд байрладаг	10
3.2	Зориулалтын бус байрыг өөрчлөн засварласан	5
3.3	Батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, зориулалтын байртай	1
Дөрөв. Цэвэр усан хангамж, бохир ус зайлуулах татуургын систем		
4.1	Хоолны газрын барилга байгууламж нь инженерийн төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй	10
4.2	Хоолны газрын шугам сүлжээ нь хэсгийн холболттой	5
4.3	Хоолны газрын барилга байгууламж нь инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Тав. Ажлын байрны гадаад орчин, тохижилт		
5.1	Хоолны газрын өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газарт ногоон байгууламж байгуулаагүй, хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах нөхцөл бүрдүүлээгүй	10
5.2	Хог хаягдал цуглуулах, хадгалах цэгийг байгуулсан боловч тээвэрлэлтийг цаг хугацаанд нь хийлгэдэггүй, бүртгэдэггүй	5
5.3	Өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газарт ногоон байгууламж байгуулаагүй, хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах нөхцөл бүрдүүлж, дотоод хяналт тавьж ажилладаг	1
Зургаа. Хүнс, түүхий эдийн тээвэрлэлтийн нөхцөл		
6.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
6.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч хүнсний бүтээгдэхүүнийг дам бохирдол үүсэхээс сэргийлсэн нөхцөлд тээвэрлэхээр тоногдсон тээврийн хэрэгсэл ашигладаг	5
6.3	Зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгсэлтэй	1
Долоо. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
7.1	Хүнсний бүтээгдэхүүний агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	10
7.2	Хүнсний бүтээгдэхүүний агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгслээр хангагдаагүй	5



7.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан агуулах, тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн хангагдсан	1
Найм. Хоолны гаралтай хордлого, хордлогот халдвар гарсан байдал		
8.1	Тухайн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт хоолны гаралтай хордлого, хордлогот халдвар сүүлийн 5 жилд гарсан	10
8.2	Хоол хүнснээс гаралтай хордлого, хордлогот халдвар илэрсэн талаарх санал гомдол сүүлийн 2 жилд гарч байсан	5
8.3	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт хоолны гаралтай хордлого, хордлогот халдвар гараагүй	1
Ес. Өмнөх хяналт шалгалтын түүх		
9.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
9.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
9.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
Арав. Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байдал		
10.1	Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг томилох буюу гэрээгээр ажиллуулаагүй	10
10.2	Дотоод хяналтын алба/ажилтантай боловч, үйл ажиллагаа хэвшээгүй	5
10.3	Дотоод хяналт тогтмолжсон, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг томилж ажиллуулсан	1

Үнэлгээ:

50–100 оноо авсан бол их эрсдэлтэй

30–49 оноо авсан бол дунд эрсдэлтэй

29 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

10.13. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, худалдаа, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөөр эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Худалдааны газар, агуулахын ажлын байрны нөхцөл		
1.1	Худалдааны газар, агуулах нь батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, технологийн урсгалыг зөв зохион байгуулаагүй	10
1.2	Худалдааны газар, агуулах нь батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй боловч технологийн урсгалыг зөв зохион байгуулсан	5
1.3	Худалдааны газар, агуулах нь батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, технологийн урсгалыг зөв зохион байгуулсан	1
Хоёр. Усан хангамжийн нөхцөл		
2.1	Барилга байгууламж нь инженерийн төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбоогүй, зөөврийн усан хангамжтай	10



2.2	Барилга байгууламжийн шугам сүлжээ нь хэсгийн шугам сүлжээнд холбогдсон	5
2.3	Барилга байгууламж нь инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Гурав. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
3.1	Стандартын шаардлага хангасан агуулахгүй, хүнсийг горимын дагуу хадгалах шаардлага хангасан тоног төхөөрөмж, хэрэгсэлгүй	10
3.2	Стандартын шаардлага хангасан агуулахтай боловч хүнсийг горимын дагуу хадгалах шаардлага хангасан тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдаагүй	5
3.3	Стандартын шаардлага хангасан агуулах, тоног төхөөрөмж, хэрэгслээр бүрэн хангагдсан	1
Дөрөв. Тээвэрлэлтийн нөхцөл		
4.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
4.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч хүнсний бүтээгдэхүүнийг дам бохирдол үүсэхээс сэргийлсэн нөхцөлд тээвэрлэхээр тоногдсон тээврийн хэрэгсэл ашигладаг	5
4.3	Зориулалтын, хөргүүртэй тээврийн хэрэгсэлтэй	1
Тав. Дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлсэн байдал		
5.1	Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй	10
5.2	Дотоод хяналтын алба/ажилтантай боловч, үйл ажиллагаа хэвшээгүй	5
5.3	Дотоод хяналт тогтмолжсон	1
Зургаа. Хүнсний гаралтай хордлого, хордлогот халдвар гарсан, мал, амьтны өвчний үүсгэгч илэрсэн байдал		
6.1	Худалдаалах, хадгалах үе шатнаас шалтгаалсан хоол, хүнсний гаралтай хордлого, хордлогот халдвар сүүлийн 2 жилд гарсан, мал, амьтны өвчний үүсгэгч, нян, бактери, вирус илэрсэн	10
6.2	Худалдаалах, хадгалах үе шатнаас шалтгаалсан хоол, хүнсний гаралтай хордлого, хордлогот халдвар болон мал, амьтны өвчний үүсгэгч, нян, бактери, вирус илэрсэн талаарх санал, гомдол сүүлийн 1 жилд гарсан	5
6.3	Худалдаалах, хадгалах үе шатнаас шалтгаалсан хоол, хүнсний гаралтай хордлого, хордлогот халдвар болон мал, амьтны өвчний үүсгэгч, нян, бактери, вирус илрээгүй	1
Долоо. Өмнөх хяналт шалгалтын түүх		
7.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
7.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
7.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

35-70 оноо авсан бол их эрсдэлтэй,
21-34 оноо авсан бол дунд эрсдэлтэй
20 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

10.14. Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт (эм, биобэлдмэлийн хяналт)

Тус шалгуураар эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч дараах эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч этгээдийг үнэлнэ.

1.Эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч этгээд

2.Уламжлалт анагаах ухааны эмийн үйлдвэр

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Үйлдвэрлэлийн технологийн онцлог		
1.1	Тарилгын эм, антибиотик, биобэлдмэл үйлдвэрлэдэг	10
1.2	1.1-д зааснаас бусад нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвх бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	1
Хоёр. Үйлдвэрийн хүчин чадал		
2.1	10-аас дээш нэр төрлийн эм бэлдмэл үйлдвэрлэдэг	10
2.2	5-10 нэр төрлийн эм бэлдмэл үйлдвэрлэдэг	5
2.3	5 хүртэл нэр төрлийн эм бэлдмэл үйлдвэрлэдэг	1
Гурав. Үйлдвэрийн барилга, байгууламж		
3.1	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй барилга байгууламж, тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй	10
3.2	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар зөв зохион байгуулсан	5
3.3	Үйлдвэрлэлийн батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламжтай, үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар зөв зохион байгуулж, орц гарцыг шаардлагын дагуу гаргасан	1
Дөрөв. Үйлдвэрийн агааржуулалт		
4.1	Шаардлага хангасан агааржуулалтын системгүй, хянах төхөөрөмжгүй	10
4.2	Агааржуулалтын системтэй боловч, хяналтын төхөөрөмжгүй	5
4.3	Хяналтын төхөөрөмж бүхий шаардлага хангасан агааржуулалтын системтэй	1
Тав. Усан хангамж		
5.1	Төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй	10
5.2	Хэсгийн холболттой	5
5.3	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Зургаа. Тээвэрлэлтийн нөхцөл		
6.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10



6.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч, температурын шаардлага хангахуйц тоноглонсон тээврийн хэрэгсэлтэй	5
6.3	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй	1
Долоо. Үйлдвэрийн дотоод хяналтын лаборатори		
7.1	Дотоод хяналтын лабораторигүй	10
7.2	Дотоод хяналтын лабораторитой боловч итгэмжлэгдээгүй	5
7.3	Итгэмжлэгдсэн лабораторитой	1
Найм. Эм, бүтээгдэхүүний чанар		
8.1	Сүүлийн 2 хүртэлх жилийн хугацаанд хөндлөнгийн хяналтаар авсан дээж лабораторийн шинжилгээгээр шаардлага хангаагүй дүнтэй гарсан	10
8.2	Сүүлийн 2 хүртэлх жилийн хугацаанд хөндлөнгийн хяналтаар авсан дээж лабораторийн шинжилгээгээр шаардлага хангасан дүнтэй гарсан	1
Ес. Эмийн гомдол мэдээлэл, гаж нөлөө, буцаалт, татан авалт гарсан байдал		
9.1	Сүүлийн 3 хүртэлх жилд үйлдвэрлэсэн эм, бүтээгдэхүүнтэй холбоотой санал, гомдол, мэдээлэл ирсэн, эмийн гаж нөлөө, буцаалт, татан авалт хийгдэж байсан	10
9.2	Сүүлийн 3-5 хүртэлх жилд үйлдвэрлэсэн эм, бүтээгдэхүүнтэй холбоотой санал, гомдол, мэдээлэл ирсэн, эмийн гаж нөлөө, буцаалт, татан авалт хийгдэж байсан	5
9.3	Сүүлийн 5 хүртэлх жилд үйлдвэрлэсэн эм, бүтээгдэхүүнтэй холбоотой санал, гомдол, мэдээлэл ирээгүй, эмийн гаж нөлөө, буцаалт, татан авалт хийгдээгүй	1
Арав. Үйлдвэрлэлийн зохистой дадал		
10.1	Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлээгүй	10
10.2	Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлсэн	1
Арван нэг.Түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл		
11.1	Зориулалтын агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	10
11.2	Агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	5
11.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан агуулах, тоног төхөөрөмж хэрэгсэлээр бүрэн хангагдсан	1
Арван хоёр. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээлэл		
12.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
12.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
12.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

60-120 оноо авсан бол их эрсдэлтэй
36-59 оноо авсан бол дунд эрсдэлтэй
35 буюу түүнээс бага оноо авсан бол бага эрсдэлтэй

10.15.Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт (эм биобэлдмэлийн хяналт)

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Үйл ажиллагааны төрөл		
1.1	Эм найруулдаг эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага	10
1.2	Эм найруулдаггүй эмийн сан	5
Хоёр. Ажлын байрны нөхцөл		
2.1	Батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, технологийн урсгалыг зөв зохион байгуулаагүй, шаардлагатай өрөө тасалгаагаар бүрэн хангагдаагүй	10
2.2	Батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй боловч технологийн урсгалыг зөв зохион байгуулж шаардлагатай өрөө тасалгаагаар бүрэн хангагдсан	5
2.3	Батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, технологийн урсгалыг зөв зохион байгуулж шаардлагатай өрөө тасалгаагаар бүрэн хангагдсан	1
Гурав. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн үйлчилгээ		
3.1	Үйлчилдэг	10
3.2	Үйлчилдэггүй	1
Дөрөв. Стандартад заагдсан эм зүйн мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал		
4.1	Хангагдаагүй	10
4.2	Хангагдсан	1
Тав. Усан хангамж		
5.1	Төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй	5
5.2	Хэсгийн холболттой	3
5.3	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1
Зургаа. Дулаан хангамж		
6.1	Төвлөрсөн болон хэсгийн халаалтын системд холбогдоогүй	5
6.2	Хэсгийн халаалттай	3
6.3	Төвлөрсөн халаалтын системд холбогдсон	1
Долоо. Эм, эмнэлгийн хэрэгслийн тээвэрлэлтийн нөхцөл		
7.1	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус	10
7.2	Тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус боловч, температурын шаардлага хангахуйц тоногдсон тээврийн хэрэгсэлтэй	5
7.3	Зориулалтын тээврийн хэрэгсэлтэй	1
Найм. Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалтын нөхцөл		
8.1	Зориулалтын агуулахгүй, хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	10
8.2	Агуулахтай боловч хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан тоног төхөөрөмж хэрэгсэлгүй	5



8.3	Хадгалалтын горимын нөхцөл шаардлагыг хангасан агуулах, тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн хангагдсан	1
Ес. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээлэл		
9.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
9.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
9.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

40-80 оноо авсан бол их эрсдэлтэй

24-39 оноо авсан бол дунд эрсдэлтэй

23 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

10.16.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрхлэгч этгээдийг эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт (эм, биобэлдмэлийн хяналт)

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Эм зүйн тусламж, үйлчилгээний хүрээ		
1.1	Төлөвлөгөөт болон яаралтай мэс засал хийдэг, төрөх тасагтай, нярайн тасагтай, халдварт, хавдрын эмчилгээ хийдэг	10
1.2	Мэс ажилбар хийдэг	5
1.3	Мэс засал болон мэс ажилбар хийдэггүй	3
Хоёр. Эмийн зохистой хэрэглээний зохицуулалт		
2.1	Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жилд 25000-аас дээш, эсвэл амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо жилд 6000-аас дээш бол	10
2.2	Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жилд 15000-25000 хүртэл, эсвэл амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо жилд 2000-6000 хүртэл	5
2.3	Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жилд 15000-аас доош, эсвэл амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо жилд 2000-аас доош	3
Гурав. Эм зүйн мэргэжлийн боловсон хүчний хангалт		
3.1	Стандартад заасан орон тоо 80 хувиас доош хангагдсан	10
3.2	Стандартад заасан орон тоо 80-90 хувь хангагдсан	5
3.3	Стандартад заасан орон тоо 100 хувь хангагдсан	1
Дөрөв. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж		
4.1	Эм, эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авалтаар авдаг (тендер бус)	10
4.2	Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн нийлүүлэлттэй, мөн шууд худалдан авалтаар авдаг	5
4.3	Эм, эмнэлгийн хэрэгслийг зөвхөн тендерээр авдаг	1
Тав. Лабораторийн урвалж оношлуурын эм зүйн дэглэм		



5.1	Нян судлал, вирус, биопси, гистологи, цитологи, иммунологи, молекул биологийн шинжилгээ хийдэг	10
5.2	Клиник, биохими	5
5.3	Лабораторийн шинжилгээ хийдэггүй	0
Зургаа. Дархлаажуулалт, эмийн эмчилгээний онцлог		
6.1	Дархлаажуулалт болон эмийн эмчилгээ хийдэг	10
6.2	Дархлаажуулалт болон эмийн эмчилгээний аль нэгийг хийдэг	5
6.3	Дархлаажуулалт хийдэггүй, эмийн эмчилгээ хийдэггүй	1
Долоо. Өмнөх хяналт шалгалтын түүх		
7.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
7.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
7.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

35-70 оноо авсан бол их эрсдэлтэй

21-34 оноо авсан бол дунд эрсдэлтэй

20 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

---o0o---



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 195 дугаар
тогтоолын 11 дүгээр хавсралт

**11. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОБЪЕКТЫГ
ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Зориулалт		
1.1	Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх	10
1.2	Цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах, импортлох	
1.3	Технологийн зориулалттай зуух, даралтат сав, шугам хоолой эзэмших	
1.4	Цахилгаан, дулааны эрчим хүч түгээх, хангах	8
1.5	Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх	5
1.6	Цахилгаан, дулааны эрчим хүч хэрэглэх	3
Хоёр. Хүчин чадал		
2.1	50 МВт болон түүнээс дээш хүчин чадалтай	10
2.2	5-50 МВт хүртэлх хүчин чадалтай	8
2.3	5 МВт хүртэлх хүчин чадалтай	5
Гурав. Хамрах хүрээ		
3.1	Нийт эрчим хүч хэрэглэгчдийн тоо 1000-аас дээш	10
3.2	Нийт эрчим хүч хэрэглэгчдийн тоо 500-1000 хүртэл	8
3.3	Нийт эрчим хүч хэрэглэгчдийн тоо 50-500 хүртэл	5
3.4	Нийт эрчим хүч хэрэглэгчдийн тоо 10-50 хүртэл	3
3.5	Нийт эрчим хүч хэрэглэгчдийн тоо 10-аас доош	1
Дөрөв. Төног төхөөрөмжийн насжилт		
4.1	Төног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан	10
4.2	Төног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа 50 хувиас дээш	8
4.3	Төног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа 20-50 хувьтай	5
4.4	Төног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа 20 хувьд хүрээгүй	3
Тав. Аваар саатал		
5.1	Сүүлийн 1 жилд төлөвлөгөөт бус "0" зогсолт хийсэн	10
5.2	Аваар саатлын тоо 1 жилд 10-аас дээш гарсан	
5.3	Аваар саатлын тоо 1 жилд 5-10 удаа гарсан	8
5.4	Аваар саатлын тоо 1 жилд 5 хүртэл гарсан	5
5.5	Аваар саатал гараагүй	0
Зургаа. Эрчим хүчний барилга, байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын зурвас		



6.1	Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчилтэй	10
6.2	Эрчим хүчний хамгаалалтын зурвасын зөрчилгүй	0
Долоо. Эрчим хүч хэрэглэгчийн зэрэглэл		
7.1	1-р зэрэглэлийн хэрэглэгч	10
7.2	2-р зэрэглэлийн хэрэглэгч	8
7.3	3-р зэрэглэлийн хэрэглэгч	5
Найм. Эрчим хүчний горим		
8.1	Батлагдсан горимын дагуу хэрэглэгчдийг эрчим хүчээр хангадаггүй, эсхүл 10-аас дээш удаа батлагдсан горимыг зөрчсөн	10
8.2	Батлагдсан горимын зөрчил жилд 5-10 удаа гарч байсан	8
8.3	Батлагдсан горимын дагуу хэрэглэгчдийг эрчим хүчээр хангадаг	0
Ес. Өмнөх хяналт шалгалтын түүх		
9.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангуулаагүй, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаагүй	10
9.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
9.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	0

Үнэлгээ:

45-90 оноо авсан бол их эрсдэлтэй

27-44 оноо авсан бол дунд эрсдэлтэй

26 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй

---о0о---



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 195 дугаар
тогтоолын 12 дугаар хавсралт

**12. СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ОБЪЕКТЫГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ
ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

**12.1. Хэмжүүр, хэмжих хэрэгсэл ашиглагч этгээд, хэмжил зүйн
мэргэжлийн байгууллагыг эрсдэлийн ангилалд хамааруулах
шалгуур, үзүүлэлт**

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Хэмжүүр, хэмжих хэрэгслийг хэрэглэх үйл ажиллагааны хүрээ, байгууллага		
1.1	-Эрүүл мэндийн байгууллага -Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт -Цэвэр ус олборлох, түгээх, бохир ус татан зайлуулах -Газрын тос, шингэрүүлсэн шатдаг хийн тээвэрлэлт, хадгалалт, борлуулалт -Бүх төрлийн лабораториуд (хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын, хүн, мал эмнэлгийн, ус цаг уур, байгаль орчны шинжилгээний, хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний гэх мэт) -Авто тээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгийн төв -Хэмжих хэрэгслийг импортлох үйлдвэрлэх, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэгч	10
1.2	Хүнсний болон хүнсний бус савласан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарууд	5
1.3	Бусад (хэмжих хэрэгсэл ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага)	1
Хоёр. Хэмжих хэрэгслийн загварын туршилт		
2.1	Загварыг батлуулж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй хэмжих хэрэгсэл ашигладаг	10
2.2	Загварын баталгааны хугацаа дууссан хэмжих хэрэгсэл ашигладаг	5
2.3	Загварыг батлуулж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлсэн хэмжих хэрэгсэл ашигладаг	0
Гурав. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт		
3.1	Хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулдаггүй	10
3.2	Хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад дутуу хамруулсан	5
3.3	Хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад бүрэн хамруулсан	0
Дөрөв. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга		
4.1	Хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулдаггүй	10



4.2	Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг эрх бүхий хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлдэг	5
4.3	Хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх итгэмжлэлтэй	0
Тав. Байгууллагын хэмжил зүйн дотоод хяналт		
5.1	Байгууллагын болон хэмжил зүйн дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй	10
5.2	Байгууллагын болон хэмжил зүйн дотоод хяналтыг дутуу хэрэгжүүлдэг	5
5.3	Байгууллагын болон хэмжил зүйн дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлдэг	0
Зургаа. Өмнөх хяналт шалгалтын түүх		
6.1	Өмнө хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгаагүй	10
6.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг дутуу арилгасан	5
6.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	0

Үнэлгээ:

30-60 оноо авсан бол их эрсдэлтэй

18-29 оноо авсан бол дунд эрсдэлтэй

17 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй



12.2. Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч байгууллагыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Сорьц тогтоолгосон бүртгэл		
1.1	Үнэт металл олборлолтын бүртгэл нь зохих хууль тогтоомжийн дагуу хийгддэггүй	10
1.2	Үнэт металл олборлолтын бүртгэл нь зохих хууль тогтоомжийн дагуу хийгддэг	0
Хоёр. Сорьцын баталгааны тэмдэг даруулах		
2.1	Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлд сорьцын баталгааны тэмдэг даруулаагүй	10
2.2	Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлд сорьцын баталгааны тэмдэг даруулсан	0
Гурав. Барааны тэмдэг		
3.1	Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлд барааны тэмдэг даруулаагүй	10
3.2	Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлд барааны тэмдэг дутуу даруулсан	5
3.3	Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлд барааны тэмдэг бүрэн даруулсан	0
Дөрөв. Баталгаатай хэмжих хэрэгсэл ашиглах		
4.1	Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн худалдаанд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэл нь шалгалт баталгаажуулалтад хамрагдаагүй	10
4.2	Үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн худалдаанд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэл нь шалгалт баталгаажуулалтад хамрагдсан	0
Тав. Үнэн зөв мэдээллээр хангах		
5.1	Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч нь барааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хэрэглэгчийг хангадаггүй	10
5.2	Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч нь барааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хэрэглэгчийг хангадаг	0
Зургаа. Тусгай зөвшөөрлийн хүрээнд		
6.1	Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан	10
6.2	Тусгай зөвшөөрөлтэй, сорьцгүй бараа худалдсан	5
6.3	Тусгай зөвшөөрөлтэй, сорьцтой бараа худалдсан	0
Долоо. Импортын үйл ажиллагаа		



7.1	Импортолсон үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн сорьц, эрдэнийн чулууны тодорхойлолт нь худалдааны гэрээ болон гэрээнд заасан сорьцын баталгааны тэмдэг, эрдэнийн чулууны тодорхойлолттой тохироогүй	10
7.2	Импортоор оруулж ирсэн үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн сорьц, эрдэнийн чулууны тодорхойлолт нь худалдааны гэрээ болон гэрээнд заасан сорьцын баталгааны тэмдэг, эрдэнийн чулууны тодорхойлолттой тохирсон	0

Үнэлгээ:

51-70 оноо авсан бол их эрсдэлтэй

26-50 оноо авсан бол дунд эрсдэлтэй

1-25 оноо авсан бол бага эрсдэлтэй

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 199

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 28^{1.7}-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

САНГИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 199 дүгээр
тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ҮНЭТ ЦААС ГАРГАХ, АРИЛЖААЛАХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцаанд энэ журмыг баримтална.

1.2.Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхэд Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

Хоёр.Нийслэлийн үнэт цаас гаргах

2.1.Нийслэл нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.1-д заасан зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно.

2.2.Нийслэлийн үнэт цаас (цаашид “НҮЦ” гэх) гаргахад Өрийн удирдлагын тухай хуулийн 19.1-д заасныг удирдлага болгож, мөн хуулийн 28¹.3, 28¹.6-д заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

2.3.Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.5-д заасны дагуу гарсан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн НҮЦ-ыг тухайн төсвийн жилд нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжихаар гаргаж болно.

2.4.Энэ журмын 2.3-т заасан шийдвэрийн дагуу НҮЦ-ыг нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд биржийн бус зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад арилжих бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбоо (цаашид “Холбоо” гэх)-нд, нийтэд санал болгон арилжих бол Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд бүртгүүлж, тус бүрийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд (цаашид “Хадгаламжийн байгууллага” гэх)-д хадгалуулж, Өрийн удирдлагын тухай хуулийн 42.3-т заасан үнэт цаасны дугаар (цаашид “ISIN дугаар” гэх) авна.

Гурав.Нийслэлийн үнэт цаас гаргагч, түүний чиг үүрэг

3.1.Нийслэлийн нэрийн өмнөөс үнэт цаас гаргагчийн чиг үүргийг Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.2-т заасны дагуу Нийслэлийн Засаг дарга (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх) хэрэгжүүлнэ.

3.2.Үнэт цаас гаргагч нь дараах чиг үүрэгтэй байна:

3.2.1.тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор НҮЦ гаргах саналаа нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид “НИТХ” гэх)-д танилцуулах;

3.2.2.НИТХ-аас энэ журмын 3.2.1-д заасан саналыг дэмжсэн шийдвэр гаргасан тохиолдолд төсөл, арга хэмжээний болон бусад холбогдох танилцуулга, НИТХ-ын шийдвэр, төсөвт тусгах саналын хамт Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.4-т заасны дагуу төсвийн жил эхлэхээс дөрвөөс доошгүй сарын өмнө санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлэх;

3.2.3.НҮЦ-ыг арилжсан мөнгөн хөрөнгийг энэ журмын 2.3-т заасан Засгийн газрын шийдвэрийн дагуу төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;

3.2.4.НҮЦ-ны арилжааны хуваарийг баталж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий мэргэжлийн холбоо болон мөн хуулийн 4.1.28-д заасан байгууллага (цаашид “Арилжаа эрхлэгч” гэх)-д хүргүүлэх;

3.2.5.НҮЦ-ны арилжааны хуваарийг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу, НҮЦ-ны арилжааны мэдэгдлийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу бэлтгэн арилжаа явагдах өдрөөс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө арилжаа эрхлэгч болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий хуулийн этгээд (цаашид “Шууд оролцогч” гэх)-ээр дамжуулан олон нийт болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

3.2.6.Арилжаа эрхлэгчээс НҮЦ-ны арилжааны мэдээлэл, судалгаа, үр дүн болон НҮЦ өмчлөгчийн талаарх холбогдох мэдээллийг тухай бүр гаргуулан авах, холбогдох хууль, журмын дагуу олон нийтэд мэдээлэх;



3.2.7.НҮЦ-ны арилжааны зохион байгуулалтын нарийвчилсан нөхцөлийг тодорхойлсон гэрээг энэ журамтай нийцүүлэн арилжаа эрхлэгчтэй байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангах;

3.2.8.НҮЦ-ны арилжааны талаарх мэдээлэл, мөнгөн хөрөнгийн ашиглалтын мэдээлэл болон эргэн төлөлтийг тухай бүр бүртгэж, мэдээллийг нэгтгэн улирал тутам санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.2.9.энэ журмын 3.2.8-д заасан мэдээлэл болон холбогдох бусад мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан тохиолдолд тухай бүр нэн даруй, үнэн зөв бэлтгэн хүргүүлэх.

3.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага НҮЦ гаргах саналын талаар дүгнэлт гаргахдаа энэ журмын 3.2.2-т заасан хугацааг баримтлах бөгөөд дараах үндэслэлээр тухайн саналыг дэмжихгүй байх, эсхүл тодорхой нөхцөл, чиглэл өгч болно:

3.3.1.хуульд заасан шаардлагыг хангаагүй, энэ журамд нийцээгүй;

3.3.2.тухайн зориулалт бүхий НҮЦ-ны арилжаагаар үүссэн өрийг буцаан төлөх чадавх, магадлал бага, тооцоолсон өгөөж хангалтгүй, НҮЦ-ыг гаргахтай холбогдсон зардал өндөр гэж үзсэн;

3.3.3.аль нэг талд давуу байдал бий болгохуйц, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 78, 80 дугаар зүйлд зааснаар дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох боломж бүрдсэн, зах зээлийг урвуулан ашиглах нөхцөл үүсэх магадлалтай гэж үзсэн;

3.3.4.хуульд заасан бусад үндэслэл.

3.4.Үнэт цаас гаргагч нь НҮЦ гаргах зардал, үйлчилгээний хураамж, шимтгэл болон бусад зардлыг бүрэн хариуцах бөгөөд хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг нийслэлийн төсөвт тусган батлуулна.

3.5.НҮЦ-ны өрийн үйлчилгээний төлбөрийг хуваарийн дагуу төлнө.

Дөрөв.Арилжаа эрхлэгчийн чиг үүрэг

4.1.Арилжаа эрхлэгч НҮЦ-ны арилжаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.НҮЦ-ны арилжааг зохион байгуулах цахим системээр хангах, түүний найдвартай, шуурхай, аюулгүй, шууд оролцогчдод ашиглахад хялбар байдлыг бүрдүүлэх;

4.1.2.НҮЦ-ны арилжааны хуваарь болон мэдэгдлийг үнэт цаас гаргагчаас хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу өөрийн цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, арилжааг зохион байгуулах;

4.1.3.НҮЦ-ны арилжаа эхлэхэд шууд оролцогчоос арилжаанд оролцох саналыг хүлээн авах;

4.1.4.арилжааны цахим системээс арилжаанд оролцогчдын ирүүлсэн саналыг тухайн арилжааны санал оруулах хугацаа дуусах хүртэл үнэт цаас гаргагч болон бусад оролцогчид харах боломжгүй байхаар зохион байгуулах;

4.1.5.НҮЦ-ны арилжааны хэлцлийн мэдээллийг хадгаламжийн байгууллага болон үнэт цаас гаргагчид хүргүүлэх;

4.1.6.НҮЦ-ны арилжааны үр дүнг өөрийн цахим сүлжээгээр дамжуулан холбогдох хууль, журмын дагуу олон нийтэд мэдээлэх;

4.1.7.НҮЦ-ны арилжааны зах зээлийн хандлагын талаарх судалгаа, шинжилгээ хийж үнэт цаас гаргагчийг мэдээллээр хангах;

4.1.8.НҮЦ-ны зах зээлийн ил тод байдлыг хангах.

Тав.НҮЦ-ны арилжааны шууд болон шууд бус оролцогч

5.1.НҮЦ худалдах, худалдан авах иргэн, хуулийн этгээд (цаашид “Шууд бус оролцогч” гэх) нь НҮЦ-ны арилжаанд шууд оролцогчоор дамжуулан оролцох бөгөөд шууд оролцогч нь шууд бус оролцогчийн нэрийн өмнөөс НҮЦ-ны арилжаанд оролцохдоо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1.арилжааны хуваарь болон мэдэгдлийг шууд бус оролцогчид хүргэх;

5.1.2.шууд бус оролцогчийн эрх ашгийг төлөөлөх, түүнийг НҮЦ-ны талаар үнэн зөв мэдээллээр хангах;

5.1.3.шууд бус оролцогчийн НҮЦ худалдах, худалдан авах саналыг хүлээн авах, түүнийг төлөөлөн НҮЦ-ны арилжаанд оролцох, арилжааны үр дүнг мэдэгдэх;

5.1.4.НҮЦ-ыг худалдан авах хэмжээ, хүүгийн саналыг арилжааны мэдэгдэлд дурдсан цагт багтаан арилжаа эрхлэгчийн арилжааны цахим системд оруулах.

5.2.Шууд бус оролцогч нь хадгаламжийн байгууллага, эсхүл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.10-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд үнэт цаасны данстай байна.

Зургаа.НҮЦ-ны арилжаа

6.1.Үнэт цаас гаргагч нь арилжааны мэдэгдэлд заасан хэмжээнээс бага хэмжээний үнэт цаасыг арилжаалж болох бөгөөд энэ талаарх үндэслэл, тайлбараа арилжааны үр дүнд тусган нийтэд мэдээлнэ.

6.2.Үнэт цаас гаргагч дангаараа, эсхүл арилжаа эрхлэгчийн мэдээлэл, санал, зөвлөмжид үндэслэн НҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд шууд оролцогчдыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд тодорхойлсны дагуу зах зээлийг урвуулан ашигласан гэж үзсэн, эсхүл өндөр хүүгийн санал ирүүлсэн бол саналыг цуцлах эрхтэй.

6.3.НҮЦ-ны арилжааг эрчим хүчний саатал, программ хангамжийн гэмтэл зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан цуцалж болно.

6.4.Үнэт цаас гаргагч нь арилжааг цуцалсан тохиолдолд Хороо болон хадгаламжийн байгууллагад мэдэгдэж, НҮЦ-ыг бүртгэлээс хасуулах бөгөөд арилжааг цуцалсан үндэслэл, тайлбарыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон олон нийтэд тухайн өдөртөө багтаан мэдээлнэ.

Долоо.Хаалттай арилжаа

7.1.Нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжих НҮЦ-ны арилжааны хүү, хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тухай бүр энэ журмын 3.2.1-д заасан танилцуулгад тодорхой тусгасан байна.

7.2.Нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжих НҮЦ-ны арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.3-т заасан биржийн бус зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад арилжаалж болох бөгөөд энэ журмын 2.3-т заасан шийдвэрийг үндэслэн Холбоотой гэрээ байгуулсан байна.

Найм.НҮЦ-ны төлбөр тооцоо

8.1.Хадгаламжийн байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 51.1.2-т заасны дагуу төлбөрийн болон тооцооны үйл ажиллагааг хавсран эрхэлнэ.

8.2.Хадгаламжийн байгууллага нь үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр НҮЦ-ыг хадгалж, бүртгэж, өмчлөх эрхийг шилжүүлж, төлбөр тооцоог гүйцэтгэх бөгөөд НҮЦ-тай холбоотой бүртгэл хөтлөн үнэт цаас гаргагчийг шаардлагатай мэдээллээр тухай бүр хангана.

8.3.Хадгаламжийн байгууллага нь ISIN дугаарыг НҮЦ тус бүрд арилжаа эрхлэхээс өмнө олгож, бүртгэл хөтөлнө.

8.4.Хадгаламжийн байгууллага нь арилжааны хуваарилалт хийсний дараа арилжаанд оролцогч хэлцлийн дагуу төлбөл зохих төлбөрийг тус бүрээр тодорхойлж, холбогдох санхүүгийн бүртгэл, тооцооллыг хийж, үнэт цаас худалдан авагчаас төлөх төлбөрийг нийслэлийн төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

8.5.Үнэт цаас гаргагч нь НҮЦ-ны арилжааны мэдээллийг Өрийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Өрийн удирдлагын тухай хуулийн 19.9-д заасан хугацаанд ирүүлнэ.

Ес.Бусад

9.1.Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.5-д заасан Хорооны тусгай зөвшөөрөлтэй анддеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй үйлчилгээний хөлсийг хамгийн бага байх нөхцөлийг тусган гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажиллаж болно.

9.2.НҮЦ гаргах ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд зааснаас гадна дараах байдлаар хяналт тавина:

9.2.1.НИТХ шаардлагатай тохиолдолд НҮЦ-ны өрийн үйлчилгээний гүйцэтгэл, төсөөлөлтэй танилцах, үнэт цаас гаргагчийн тайланг хэлэлцэх, зохих чиглэл, даалгавар өгөх;

9.2.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадвар, орлогын



төлөвлөгөөний биелэлтэд тухай бүр хяналт тавих, шаардлагатай мэдээллийг гаргуулах, зохих чиглэл, зөвлөмж өгөх;

9.2.3.Хороо арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой журмын хэрэгжилт, арилжаанд оролцогчдын эрх ашиг болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, эрсдэл, ил тод байдалд холбогдох хуулийн дагуу тухай бүр хяналт тавих, шаардлагатай мэдээллийг гаргуулах, шийдвэрлэх, зөвлөмж өгөх.

9.3.Үнэт цаас гаргагч болон арилжаа эрхлэгч нь арилжааны хуваарилалт хийх хүртэлх хугацаанд арилжааны саналын нууц болон нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжих НҮЦ-ны арилжааны саналын талаарх мэдээллийг хуульд заасны дагуу эрх бүхий төрийн байгууллагад мэдээлэх, зохих шийдвэр гаргуулах, санал авахаар өгөхөөс бусад тохиолдолд тухайн саналын нууцыг хадгална.

---o0o---



“Нийслэлийн үнэт цаас гаргах,
арилжаалах, мэдээлэх журам”-ын
1 дүгээр хавсралт

АРИЛЖААНЫ ХУВААРЬ

Үнэт цаасны төрөл	
Үнэт цаасны зориулалт	
Үнэт цаасны хугацаа	
НҮЦ гаргах дээд хэмжээ	
Арилжааны хэлбэр	
Зарлах өдөр	
Арилжааны өдөр	
Төлбөр тооцооны өдөр	

“Нийслэлийн үнэт цаас гаргах,
арилжаалах, мэдээлэх журам”-ын
2 дугаар хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ
АРИЛЖААНЫ МЭДЭГДЭЛ**

Үнэт цаасны төрөл	
Үнэт цаасны зориулалт	
Үнэт цаасны хугацаа	
Арилжаалах үнэт цаасны тоо ширхэг	
Олон улсын үнэт цаасны бүртгэлийн дугаар (ISIN)	
Арилжаа явагдах огноо	
Төлбөр тооцоо хийх огноо	
Үнэт цаасны хугацаа дуусах огноо	
Үнэт цаасны өгөөжийн хувь	(арилжааны үр дүнгээр тодорхойлно)
Купоны хувь хэмжээ	
Хүү (купон) төлөх давтамж	
Хүү (купон) төлөх огноо	
Арилжааны хэлбэр	
Өрсөлдөөнт бус санал хүлээж авах цаг	
Өрсөлдөөнт санал хүлээж авах цаг	
Өрсөлдөөнт нийт саналд хуваарилах дээд хэмжээ	
Шууд/шууд бус оролцогчийн өрсөлдөөнт бус саналд хуваарилах дээд хэмжээ	

----o0o----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 200

Улаанбаатар
хот

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай

Боловсролын тухай хуулийн 40.3, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”-ийг 1 дүгээр хавсралт, “Төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ”-г 2 дугаар хавсралт, “Мэргэжлийн боловсрол, сургалтын хувьсах зардлы итгэлцүүр”-ийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад олон улсын жишиг хөтөлбөрийг турших ажлыг Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт даалгасугай.

3.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй нь уялдуулан санхүүжүүлж байх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.

4.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын бүтэц, хэв шинжийг оновчтой хэлбэрээр шинэчлэн зохион байгуулах, төсвийн гүйцэтгэл, үр дүнг холбогдох судалгаа, шинжилгээнд үндэслэн үнэлэх, тайлагнах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан даалгасугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 94 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН



Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

1. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив

(Мянган.төгрөг)

№	Хөтөлбөрийн агуулга	Өртгийн хэмжээ	Техникийн боловсрол						Мэргэжлийн боловсрол		
			1.5 жил			3 жил			1 жил		
			1-р курс	2-р курс	1-р курс	2-р курс	3-р курс	1-р курс	1-р курс	2-р курс	3-р курс
1.	Бүрэн дунд боловсрол олгох ерөнхий эрдмийн сургалт	2850	992.7	232.8	2280.0	570.0	0.0	0.0	1425.0	1425.0	0.0
2.	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжлийн суурь чадамж олгох сургалт	2250	961.9	320.6	1282.5	585.0	382.5	1125.0	562.5	438.8	123.8
3.	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшүүлэх чадамж олгох сургалт	3250	503.1	666.9	0.0	1105.0	2145.0	1722.5	876.9	830.7	600.0

2. Мэргэжлийн болон техникийн боловсролын бүрэн дунд боловсрол олгох ерөнхий эрдмийн сургалтын хувьсах зардлын бүрэлдэхүүн

№	Бүрэлдэхүүн	Хувьсах зардлын хэмжээ
A	Нийт хувьсах зардал	2850
1.	Багшийн үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	58%
2.	Багшийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	22%
3.	Сургалтын хэрэглэгдэхүүн	4%
4.	Бусад хувьсах зардал	16%
Б	Эх үүсвэр (хувь)	100%
1.	Төрөөс харуцах зардлын хувь хэмжээ	100%
2.	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-

3. Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн суурь чадамж олгох сургалтын хувьсах зардлын бүрэлдэхүүн

№	Бүрэлдэхүүн	Хувьсах зардлын хэмжээ
A	Нийт хувьсах зардал	2250
1.	Багшийн үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	45.4%
2.	Багшийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	17.5%
3.	Сургалтын хэрэглэгдэхүүн	8.1%
4.	Бусад хувьсах зардал	29.0%
Б	Нийт эх үүсвэр (хувь)	100%
1.	Төрөөс харуцах зардлын хувь хэмжээ	100%
2.	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-



4. Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэшүүлэх чадамж олгох сургалтын хувьсах зардлын бүрэлдэхүүн

(Мянган.төгрөг)

№	Бүрэлдэхүүн	Хувьсах зардлын хэмжээ
A	Нийт хувьсах зардал	3250
1.	Багшийн үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	51.4%
2.	Багшийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	17.5%
3.	Сургалтын хэрэглэгдэхүүн	3.5%
4.	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2.0%
5.	Дадлага ажлын материал, тоног төхөөрөмж	9.6%
6.	Бусад хувьсах зардал	16.0%
Б	Нийт эх үүсвэр (хувь)	100%
1.	Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ	100%
2.	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-

-----000-----



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 200 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРИЙН БУС ӨМЧИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН НЭГ СУРАЛЦАГЧИД
НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

(Мянган.төгрөг)

№	Хөтөлбөрийн агуулга	Техникийн боловсрол						Мэргэжлийн боловсрол		
		1.5 жил		3 жил		1 жил		2.5 жил		
		1-р курс	2-р курс	1-р курс	2-р курс	3-р курс	1-р курс	2-р курс	3-р курс	
1.	Бүрэн дунд боловсрол олгох ерөнхий эрдмийн сургалт	307.2	72.0	705.6	176.4	0.0	0.0	441.0	441.0	0.0
2.	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжлийн суурь чадамж олгох сургалт	291.4	97.1	388.5	177.2	115.9	340.8	170.4	132.9	37.5
3.	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшүүлэх чадамж олгох сургалт	175.5	232.7	0.0	385.6	748.4	601.0	306.0	289.9	209.4

-----000-----

Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 200 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХУВЬСАХ ЗАРДЛЫН ИТГЭЛЦҮҮР

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын байршлаас хамаарсан итгэлцүүр

№	Байршил	Итгэлцүүр
1.	Аймгийн төвд	1.35
2.	Сумын төвд	1.7

2. Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөр, мэргэжлийн өөрийн өртгийн итгэлцүүр

№	Салбар	Мэргэжил	Итгэлцүүр
1.	Аж үйлдвэрийн салбар	Сүлжмэлийн үйлдвэрийн технологийн ажилтан	1.21
2.	Аж үйлдвэрийн салбар	Ангийн ус, арьс, савхин бүтээгдэхүүний оёдолчин	1.21
3.	Аж үйлдвэрийн салбар	Арьс, шир боловсруулалтын технологийн ажилтан	1.21
4.	Аж үйлдвэрийн салбар	Гагнуурчин	1.19
5.	Аж үйлдвэрийн салбар	Даралтат сав турбин, уур ус дамжуулах шугамын угсрагч	1.00
6.	Аж үйлдвэрийн салбар	Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, самар боловсруулан даршлагч үйлдвэрлэлийн технологийн ажилтан	0.80

7.	Аж үйлдвэрийн салбар	Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний ажилтан	0.90
8.	Аж үйлдвэрийн салбар	Зөөгч, бармен	0.69
9.	Аж үйлдвэрийн салбар	Исгэлтийн үйлдвэрлэлийн технологийн ажилтан	1.00
10.	Аж үйлдвэрийн салбар	Кофе бэлтгэгч (чанагч)	0.69
11.	Аж үйлдвэрийн салбар	Мах боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	1.09
12.	Аж үйлдвэрийн салбар	Металл боловсруулах машины оператор (токарь-фрезер)	1.30
13.	Аж үйлдвэрийн салбар	Мод боловсруулагч, дизайнч	1.30
14.	Аж үйлдвэрийн салбар	Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан	1.04
15.	Аж үйлдвэрийн салбар	Нэхмэлийн үйлдвэрийн технологийн ажилтан (нэхмэлчин)	1.04
16.	Аж үйлдвэрийн салбар	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	1.04
17.	Аж үйлдвэрийн салбар	Сүлжих машины оператор	1.04
18.	Аж үйлдвэрийн салбар	Сүлжмэлийн үйлдвэрийн технологийн ажилтан (сүлжигч)	1.04
19.	Аж үйлдвэрийн салбар	Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	0.86
20.	Аж үйлдвэрийн салбар	Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан	1.07
21.	Аж үйлдвэрийн салбар	Тогооч	1.14
22.	Аж үйлдвэрийн салбар	Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн механик	1.14
23.	Аж үйлдвэрийн салбар	Үйлдвэрийн цахилгаанчин	1.14
24.	Аж үйлдвэрийн салбар	Хөнгөн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин	0.84



25.	Аж үйлдвэрийн салбар	Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин	0.89
26.	Аж үйлдвэрийн салбар	Хэвлэлийн үйлдвэрийн хэвлэгч	0.89
27.	Аж үйлдвэрийн салбар	Цахилгаанчин	0.87
28.	Аж үйлдвэрийн салбар	Эрэмэлийн үйлдвэрийн технологийн ажилтан	0.79
29.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	Аяллын хөтөч	0.84
30.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтан	0.89
31.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	Ойжуулагч	1.08
32.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	Ойн аж ахуйн ажилтан	1.08
33.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	Ойн арчилгаа, ашиглалтын ажилтан	1.08
34.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	Ойн нөхөрлөлийн ажилтан	1.08
35.	Барилгын салбар	Авто зам, гүүр барилгын ажилтан (замчин)	2.09
36.	Барилгын салбар	Барилгын засал-чимэглэлчин	0.88
37.	Барилгын салбар	Барилгын мужаан	1.13
38.	Барилгын салбар	Барилгын өрөг угсрагч	1.05
39.	Барилгын салбар	Барилгын сантехникч	1.02
40.	Барилгын салбар	Барилгын цахилгаанчин	0.96
41.	Барилгын салбар	Бетон арматурчин	1.30

42.	Барилгын салбар	Зам барилгын машин механизмын оператор	1.37
43.	Барилгын салбар	Модон эдлэлийн мужаан	0.98
44.	Барилгын салбар	Өргөн тээвэрлэх тоног төхөөрөмжийн засварчин	1.07
45.	Барилгын салбар	Халаалт, агааржуулалт, хөргөлтийн тоног төхөөрөмжийн засварчин	1.07
46.	Барилгын салбар	Хуурай хийц угсрагч	0.88
47.	Барилгын салбар	Хуучин барилгын сэргээн засварлагч	0.88
48.	Барилгын салбар	Цемент, хиймэл чулуун бүтээгдэхүүн үйлдвэрлэх машины оператор	0.88
49.	Боловсролын салбар	Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч	1.50
50.	Мэдээллийн технологийн салбар	Архивын ажилтан	0.77
51.	Мэдээллийн технологийн салбар	Компьютерын оператор	0.77
52.	Мэдээллийн технологийн салбар	Мэдээлэл технологийн оператор	0.77
53.	Мэдээллийн технологийн салбар	Нарийн бичгийн дарга-албан хэргийн ажилтан	0.60
54.	Мэдээллийн технологийн салбар	Өгөгдлийн сангийн оператор	0.60
55.	Мэдээллийн технологийн салбар	Хүний нөөцийн туслах ажилтан	0.60
56.	Мэдээллийн технологийн салбар	Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан	0.60
57.	Мэдээллийн технологийн салбар	Цахим хэрэгслийн засварчин	0.60
58.	Санхүү, бизнес, худалдааны салбар	Нягтлан бодохын бүртгэл, тооцооны ажилтан	0.81

59.	Санхүү, бизнес, худалдааны салбар	Төлбөр тооцоо, цалин хөлсний нярав	0.72
60.	Санхүү, бизнес, худалдааны салбар	Хангамжийн нярав	0.72
61.	Санхүү, бизнес, худалдааны салбар	Худалдааны газрын үндсэн ажилтан (худалдагч)	0.72
62.	Соёл, урлагийн салбар	Ардын бүжгийн бүжигчин	1.4
63.	Соёл, урлагийн салбар	Ардын гоцлол хөгжимчин	1.4
64.	Соёл, урлагийн салбар	Арьсаар гар урлалын зүйл урлаач	0.85
65.	Соёл, урлагийн салбар	Бэлэг, дурсгалын зүйл урлаач	0.93
66.	Соёл, урлагийн салбар	Дуу, хөгжим чимэглэлийн найруулагч	1.4
67.	Соёл, урлагийн салбар	Зураач	1.15
68.	Соёл, урлагийн салбар	Зураач-чимэглэгч	1.15
69.	Соёл, урлагийн салбар	Монгол дархан	1.15
70.	Соёл, урлагийн салбар	Нарийн мужаан	1.15
71.	Соёл, урлагийн салбар	Орчны дизайнч	1.15
72.	Соёл, урлагийн салбар	Сийлбэрчин	1.15
73.	Соёл, урлагийн салбар	Тайзны ажилтан	1.4
74.	Соёл, урлагийн салбар	Театр, телевиз, киноны гэрэлтүүлэгч	1.4
75.	Соёл, урлагийн салбар	Төгөлдөр хуурч	1.4

76.	Соёл, урлагийн салбар	Үлээвэр, цохивор найрал хөгжмийн хөгжимчин	1.4
77.	Соёл, урлагийн салбар	Үнэт эдлэлийн дархан	1.15
78.	Соёл, урлагийн салбар	Фото зурагч	0.93
79.	Соёл, урлагийн салбар	Хувцасны дизайнерч	0.93
80.	Соёл, урлагийн салбар	Хэвлэлийн график дизайнерч	0.93
81.	Соёл, урлагийн салбар	Эстрадын хөгжимчин	1.4
82.	Тээврийн салбар	Автомашинны засварчин	0.87
83.	Тээврийн салбар	Автомашинны кузов засварчин	0.93
84.	Тээврийн салбар	Агаарын хөлгийн үйлчилгээний ажилтан	0.80
85.	Тээврийн салбар	Ачаа вагон хүлээлцэгч	0.80
86.	Тээврийн салбар	Вагон үзэгч, засварчин	1.34
87.	Тээврийн салбар	Дохиолол төвлөрүүлэлт хориглолын монтёр	1.34
88.	Тээврийн салбар	Жолооны багш	0.93
89.	Тээврийн салбар	Зорчигчийн вагоны үйлчлэгч	1.34
90.	Тээврийн салбар	Зүүтүүрийн туслах машинч	1.34
91.	Тээврийн салбар	Илчит тэрэгний засварчин	1.34
92.	Тээврийн салбар	Моторт тээврийн хэрэгслийн цахилгаанчин	1.34
93.	Тээврийн салбар	Мэргэшсэн жолооч	1.34

94.	Тээврийн салбар	Төмөр замын замчин	1.34
95.	Тээврийн салбар	Төмөр замын өртөөний жижүүр	1.17
96.	Уул уурхайн салбар	Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин	1.35
97.	Уул уурхайн салбар	Өрмийн мастер	1.35
98.	Уул уурхайн салбар	Өрмийн машины оператор	1.35
99.	Уул уурхайн салбар	Тээрэм бутлуурын операторч	1.24
100.	Уул уурхайн салбар	Уул уурхайн машин, тоног төхөөрөмжийн механик	1.24
101.	Уул уурхайн салбар	Уул уурхайн нөхөн сэргээлт	1.04
102.	Уул уурхайн салбар	Уурхайн механик	1.24
103.	Уул уурхайн салбар	Уурхайн цахилгаанчин	1.24
104.	Уул уурхайн салбар	Хөвүүлэн баяжуулахын оператор	1.04
105.	Уул уурхайн салбар	Хүдэр, чулуу боловсруулах суурин тоног төхөөрөмжийн оператор	1.04
106.	Уул уурхайн салбар	Хүнд машин механизмын засварчин	1.13
107.	Уул уурхайн салбар	Хүнд машин механизмын оператор	1.13
108.	Үйлчилгээний салбар	Гоо засалч	0.78
109.	Үйлчилгээний салбар	Гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин	0.98
110.	Үйлчилгээний салбар	Захиалгын гуталчин	1.19
111.	Үйлчилгээний салбар	Массажчин	0.78

112.	Үйлчилгээний салбар	Үсчин		0.78
113.	Хот байгуулалт, тохижилтын салбар	Төв, суурин газрын ус хангамжийн ажилтан		1.13
114.	Хот байгуулалт, тохижилтын салбар	Цэцэрлэгт хүрээлэнгийн цэцэрлэгч		1.30
115.	Хөдөө аж ахуйн салбар	Жимс, жимсгэний аж ахуйн фермер		1.30
116.	Хөдөө аж ахуйн салбар	Зөгийчин, зөгийн аж ахуй эрхлэгч		1.30
117.	Хөдөө аж ахуйн салбар	Малчин		1.30
118.	Хөдөө аж ахуйн салбар	Малын асаргаа		1.30
119.	Хөдөө аж ахуйн салбар	Тракторын механик		0.87
120.	Хөдөө аж ахуйн салбар	Уламжлалт мал аж ахуйн фермер		1.30
121.	Хөдөө аж ахуйн салбар	Фермерийн аж ахуй эрхлэгч (ГТ-МАН)		1.30
122.	Хөдөө аж ахуйн салбар	Фермерийн аж ахуй эрхлэгч (МАН-ГТ)		1.30
123.	Хөдөө аж ахуйн салбар	ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин		0.88
124.	Хөдөө аж ахуйн салбар	Хүлэмжийн аж ахуйн фермер		1.30
125.	Хөдөө аж ахуйн салбар	Хүнсний ногооны фермер		1.30
126.	Хөдөө аж ахуйн салбар	Эрчимжсэн МАН-н фермер		1.30
127.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Автотехникийн засварчин-нярав		1.00
128.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Автотехникийн цахилгаанчин		1.00



129.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Зэвсгийн засварчин-нярав	1.00
130.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Инженерийн дугуйт машины механик-жолооч	1.00
131.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Наводчик (буу)	1.00
132.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Онгоц, нисдэг тэрэгний хөдөлгүүрийн механик	1.00
133.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Радио телеграфчин	1.00
134.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Радиолокацын (пуужин чиглүүлэх) станцын оператор	1.00
135.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Тагнуулчин (гал засварлагч)	1.00
136.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Танкийн бууны дарга (танкийн буудагч)	1.00
137.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Танкийн механик-жолооч	1.00
138.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Хуягт тээвэрлэгчийн механик-жолооч	1.00
139.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Цахилгаан холбоо (компьютер сүлжээ)-ны техникч	1.00
140.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Явган цэргийн байлдааны машины механик-жолооч	1.00
141.	Цагдаа, Батлан хамгаалах, Онцгой байдлын салбар	Явган цэргийн байлдааны машины наводчик-оператор	1.00
142.	Шуудан, харилцаа холбооны салбар	Гар утас, телефон аппаратын засварчин	0.80
143.	Шуудан, харилцаа холбооны салбар	Дуу, дүрс бичлэгийн оператор	0.80
144.	Эрүүл мэндийн салбар	Туслах сувилагч	1.50

145.	Эрүүл мэндийн салбар	Эмчилгээний бариа засалч	1.20
146.	Эрчим хүчний салбар	Арматур, шугам хоолой, сантехникийн засварчин	1.32
147.	Эрчим хүчний салбар	Зуухны машинч	1.32
148.	Эрчим хүчний салбар	Нар, салхины үүсгүүртэй тоног төхөөрөмжийн угсралт, засварчин	1.32
149.	Эрчим хүчний салбар	Цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин	1.32
150.	Бусад	Бусад	1.00

3. Техникийн боловсролын сургалтын хөтөлбөр, мэргэжлийн өөрийн өртгийн итгэлцүүр

№	Салбар	Мэргэжил	Итгэлцүүр
1.	Аж үйлдвэрийн салбар	Амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн техник-технологич	1.16
2.	Аж үйлдвэрийн салбар	Аюулгүй ажиллагааны техникч	1.00
3.	Аж үйлдвэрийн салбар	Механик инженерийн техникч	1.00
4.	Аж үйлдвэрийн салбар	Мехатроникч	0.89
5.	Аж үйлдвэрийн салбар	Оёдлын техник-технологич	1.16
6.	Аж үйлдвэрийн салбар	Сүлжмэлийн үйлдвэрийн техник-технологич	1.16
7.	Аж үйлдвэрийн салбар	Ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн техник-технологич	1.06
8.	Аж үйлдвэрийн салбар	Үйлдвэрлэлийн техникч	1.16
9.	Аж үйлдвэрийн салбар	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний техник-технологич	1.06

10.	Аж үйлдвэрийн салбар	Цахилгааны техникч	0.92
11.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	Ойн техникч	1.64
12.	Барилгын салбар	Барилга угсралтын мужааны техникч	0.91
13.	Барилгын салбар	Барилгын зургийн техникч	1.00
14.	Барилгын салбар	Барилгын материалын үйлдвэрийн техник технологич	1.00
15.	Барилгын салбар	Барилгын угсралтын техникч	1.02
16.	Барилгын салбар	Барилгын цахилгааны техникч	1.02
17.	Барилгын салбар	Зам, барилгын материалын лаборант	0.83
18.	Барилгын салбар	Зам, гүүрийн техникч	1.35
19.	Барилгын салбар	Инженерийн байгууламжийн технологийн техникч	1.02
20.	Барилгын салбар	Иргэний барилгын техникч	0.87
21.	Барилгын салбар	Өргөх, зөөх механизмын техникч	1.35
22.	Барилгын салбар	Сантехник, халаалт, агааржуулалтын төхөөрөмжийн техникч	1.30
23.	Барилгын салбар	Сантехникийн техникч	0.94
24.	Боловсролын салбар	Техникийн солонгос хэлний орчуулагч	0.79
25.	Мэдээллийн технологийн салбар	Веб мультимедиа зохиогч	0.87
26.	Мэдээллийн технологийн салбар	График дизайнч	0.87

27.	Мэдээллийн технологийн салбар	Компьютерын сүлжээний техникч	0.87
28.	Мэдээллийн технологийн салбар	Мэдээллийн технологич	0.87
29.	Мэдээллийн технологийн салбар	Программ кодлогч	0.87
30.	Санхүү, бизнес, худалдааны салбар	Төлбөр тооцоо, цалин хөлсний нягтлан бодогч	0.78
31.	Соёл, урлагийн салбар	Ардын бүжгийн бүжигчин	0.85
32.	Соёл, урлагийн салбар	Зураач	0.85
33.	Соёл, урлагийн салбар	Зураач-чимэглэгч	0.85
34.	Соёл, урлагийн салбар	Интерьер дизайнч	0.85
35.	Соёл, урлагийн салбар	Сонгодог бүжгийн бүжигчин	0.85
36.	Соёл, урлагийн салбар	Төгөлдөр хуурч	0.85
37.	Соёл, урлагийн салбар	Үлээвэр, цохивор найрал хөгжмийн хөгжимчин	0.85
38.	Соёл, урлагийн салбар	Үндэсний найрал хөгжмийн хөгжимчин	0.85
39.	Соёл, урлагийн салбар	Хувцасны загвар зохион бүтээгч	0.85
40.	Соёл, урлагийн салбар	Циркийн жүжигчин	0.85
41.	Соёл, урлагийн салбар	Чавхдаст хөгжмийн хөгжимчин	0.85
42.	Соёл, урлагийн салбар	Чимэглэх урлаг	0.85
43.	Тээврийн салбар	Автомашинны механик	1.17
44.	Тээврийн салбар	Вагоны техникч	1.23
45.	Тээврийн салбар	Дохиолол төвлөрүүлэлт хориглолтын техникч	1.23

46.	Тээврийн салбар	Замын техникч	1.23
47.	Тээврийн салбар	Зүтгүүрийн техникч	1.23
48.	Тээврийн салбар	Төмөр замын ашиглалтын техникч	1.23
49.	Тээврийн салбар	Төмөр замын машин механизмын техникч	1.23
50.	Уул уурхайн салбар	Баяжуулалтын техникч	1.10
51.	Уул уурхайн салбар	Газрын тосны техникч	1.13
52.	Уул уурхайн салбар	Геологийн техникч	1.10
53.	Уул уурхайн салбар	Уул уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны техникч	1.15
54.	Уул уурхайн салбар	Уулын ажлын техникч	1.15
55.	Уул уурхайн салбар	Хүнд машин механизмын ашиглалтын техникч	1.15
56.	Үйлчилгээний салбар	Гоо заслын технологич	0.75
57.	Үйлчилгээний салбар	Үс заслын технологич	0.87
58.	Хөдөө аж ахуйн салбар	Агротехникч	1.20
59.	Хөдөө аж ахуйн салбар	Зоотехникч	0.91
60.	Хөдөө аж ахуйн салбар	Малын бага эмч	0.91
61.	Хөдөө аж ахуйн салбар	Хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийн техникч	1.15
62.	Эрчим хүчний салбар	Дулааны шугам сүлжээний техникч	1.21
63.	Эрчим хүчний салбар	Хуваарилах байгууламж сэлгэн залгалтын оператор	1.30
64.	Эрчим хүчний салбар	Цахилгаан станц, сүлжээний техникч	1.18
65.	Бусад	Бусад	1.16

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 202

Улаанбаатар
хот

Жагсаалт шинэчлэн батлах тухай

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5.1.5 дахь заалт, 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Жагсаалт шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 164 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ж.ГАНБААТАР



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 24-ний өдрийн 202 дугаар
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЭРГЭЛТИЙГ ЗӨВШӨӨРӨХ, ОЛОН
УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ
ХЭРЭГСЭЛ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭДИЙН ЖАГСААЛТ**

№	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрөл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрлийн хэлбэрүүд	БТКУС код
А	Б	В	Г
Нэг. Тэсэлгээний хэрэгсэл			
1.	Цахилгаан тэслүүр	агшны	3603
		удаашруулалттай	
		хамгаалалттай	
		газрын тос, хийн цооногийн	
2.	Галын бялт тэслүүр	агшны хонгиотой	3603
3.	Цахилгаан бус тэслүүр	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
4.	Цахилгаан бус тэслүүрийн систем	цооног, шпурын	3603
		гадаргуугийн холбогч блоктор	
		цооногийн болон гадаргуугийн холбогч блоктор хосолсон	
5.	Цочир дамжуулах шижмийн гадаргуугийн удаашруулагч систем	очир дамжуулах шижмээр холбох	3603
		цохилтын долгион дамжуулах гүүрстай холбогч блоктор	
6.	Цахим тэслүүр	утастай	3603
		утасгүй	
7.	Цохилтын долгион дамжуулах гурц	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүргүй	
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүртэй	
8.	Гал дамжуулах шижим		3603
9.	Гал дамжуулах шижмийн асаагуур	галын	3603
		цахилгааны	



Хоёр. Тэсрэх бодис			
10.	Цэнэг өдөөх тэсрэх бодисын хэрэгсэл бэлтгэх өндөр хүчин чадалтай тэсрэх бодис	RDX	3602
		TNT	3602
		PETN	3602
		PETN, TNT холимог	3602
11.	Өдөөгч тэсрэх бодис	цооног, шпурын	3602
		чиглэсэн үйлчлэлтэй гадаргуугийн	
12.	Перфорацийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
13.	Прессплитийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
14.	Аммонит тэсрэх бодис	боодолтой, хамгаалалттай	3602
15.	Динамит тэсрэх бодис	бортоготой, чичирхийллийн	3602
16.	Гранулит тэсрэх бодис	мөхлөгтэй, задгай	3602
17.	Анфо тэсрэх бодис	энгийн найрлагатай, савлагаатай	3602
		нэмэлт хольцтой, савлагаатай	
		энгийн найрлагатай, задгай	
		хүнд анфо савлагаатай	
18.	Эмульсийн тэсрэх бодис	савлагаатай, тэслүүрт мэдрэмтгий савлагаатай, тэслүүрт, мэдрэмтгий бус	3602
		задгай	
		анфогийн хольцтой задгай	
19.	Цочир дамжуулах шижим	гадаргуугийн холболтын бага хүчин чадлын	3602
		өндөр хүчин чадлын	
		газрын тос, хийн цооногийн	
Гурав. Үндсэн түүхий эд			
20.	Аммиакийн шүү	аммиакийн шүү цэвэр	3102.30
		аммиакийн шүү сүвэрхэг	3102.30
21.	Аммиакийн шүүний эмульс	задгай, мэдрэгжүүлээгүй	дотоодод зөвшөөрөгдөх

----oO----



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 11.5

Индекс: 200003